



МОНГОЛЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН



ХСИС
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН



ХҮЙСИЙН ТЭГШ
ЭРХ ТӨВ

ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ШАЛТГААН, НӨЛӨӨЛЖ
БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС



СУДАЛГААНЫ ТАЙЛАН



МОНГОЛЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН



ХСИС
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН



ХҮЙСИЙН ТЭГШ
ЭРХ ТӨВ

ХҮҮХДИЙН

БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН

ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ШАЛТГААН, НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2019 он

Захиалагч: Монголын Эмэгтэйчүүдийн сан
Хүйсийн тэгш эрх төв

Гүйцэтгэгч: Хууль сахиулахын их сургууль,
Эрдэм шинжилгээний хүрээлэн, Цагдаа судлалын төв

СУДАЛГААНЫ БАГ

Багийн ахлагч:

Т.Оюунчимэг ХСИС, ЭШХ, ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
хууль зүйн доктор (Ph.D), профессор

Зөвлөх:

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Гишүүд:

1. М.Эрдэнэбаяр ХСИС, ЭШХ-ийн захирал, хууль зүйн доктор (Ph.D)
2. Ч.Нямсүрэн ХСИС, ЭШХ, ЦСТ-ийн эрхлэгч,
хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор
3. Б.Мөнхдорж ХСИС, ЭШХ, ЦСТ-ийн эрдэм шинжилгээний ахлах
ажилтан, хууль зүйн доктор (Ph.D)
4. О.Уулзахжаргал ХСИС, ЭШХ, Хууль сахиулахуйн инновацийн төвийн
эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр
5. С.Байгальмаа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв,
Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникийн эрхлэгч
6. Э.Бямбажаргал ХСИС, АШБС-ийн магистрант, цагдаагийн ахмад

Техник редактор: Б.Мөнхсэргэлэн (LLM)

Хэвлэсэн тоо: 1000

Цаасны хэмжээ: 176x250

Хэвлэлийн хуудас: 6.3

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
УДИРТГАЛ	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.	
ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	
1.1. Цагдаагийн байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	8
1.2. Прокурорын байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	12
1.3. Шүүхийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	15
1.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	16
1.5. Шүүхийн шинжилгээний байгууллагын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	20
1.6. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ	21
ХОЁРДУГААР БҮЛЭГ.	
ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ҮНДЭСЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ (Нийслэлийн хэмжээнд)	
2.1. Эрүүгийн хэргийн судалгаа (2015-2017)	23
2.2. Хэрэгсэхгүй болгосон хэргүүдэд хийсэн дүн шинжилгээ	25
2.3. Мөрдөн шалгах ажиллагааны талаар	28
2.4. Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад гарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар мэргэжилтнүүдтэй хийсэн бүлгийн ярилцлага	31
ГУРАВДУГААР БҮЛЭГ.	
МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ	
3.1. Монгол Улсын 2002, 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулалт	35
3.2. Гадаадын зарим улс орны эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийг хуульчилсан байдалд хийсэн харьцуулсан судалгаа	37
3.3. Монгол Улсын болон гадаадын зарим улс орны эрүүгийн хуулийн бэлгэсийн гэмт хэрэг үйлдсэн хүнд хүлээлгэх хариуцлагын харьцуулсан судалгаа	40
ДҮГНЭЛТ	44
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	47
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	49
ХАВСРАЛТ	52
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	74
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	75
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	76

ӨМНӨХ ҮГ

Сүүлийн жилүүдэд охидын бэлгийн халдашгүй байдал ноцтой зөрчигдөж, энэ төрлийн хэргийн тоо буурахгүй, өсөх хандлагатай байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь хүүхдийн бэлгийн халдашгүй байдлыг хөндөөд зогсохгүй Хүүхдийн эрхийн тухай хуулиар¹ тодорхойлсон эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхүүдийг зөрчиж, хязгаарлаж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл хүүхэд тус гэмт хэргийн хохирогч болсноор бүхэл амьдралаараа нөхөн сэргэхгүйгээр хохирдог учир бусад гэмт хэргээс ялгагддаг.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний дотор охидын бэлгийн халдашгүй байдлыг хангах чиглэлээр ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах нь энэ төрлийн гэмт хэргийг эрс бууруулах боломжийг олгоно гэж бид үзэж байна. Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг байгууллагуудад тухайн гэмт хэргийн учир шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийн талаарх бодит тоо баримт, нотолгоонд суурилсан мэдээлэл хэрэгтэй байна.

Охидын бэлгийн халдашгүй байдлыг хангахад нотолгоонд суурилсан мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Монголын эмэгтэйчүүдийн сангаас Хүйсийн тэгш эрх төв, Хууль сахиулах их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд, судлаачдад хүсэлт тавьж **“Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” (шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс)** судалгааг хийлгэсэн юм.

Хууль сахиулах их сургуулийн эрдэмтэд, судлаачдын багийн хийсэн судалгааны хүрээнд сүүлийн гурван жилд (2015-2017) үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдлын талаар улсын хэмжээний болон Улаанбаатар хотын хэмжээний зураглал гаргахаас гадна хэргийг хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн хэргийг судалж, шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийг судалж дүгнэлт, зөвлөмж гаргасан юм. Мөн гадаадын зарим улсын хууль тогтоомжид хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын зохицуулалтын талаарх мэдээллийг оруулсан. Энэ судалгаа нь хүүхдийн бэлгийн халдашгүй байдлыг хангах чиглэлээр ажиллаж буй төр, төрийн бус олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллахад нь гол эх үүсвэр болно гэдэгт бид итгэлтэй байна.

“Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” (шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс) судалгааг хийсэн Хууль сахиулах их сургуулийн эрдэмтэн судлаачдын баг болон Хүйсийн тэгш эрх төвийн хамт олонд талархал илэрхийлье!

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

¹ Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016

УДИРТГАЛ

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод 1990 онд, Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тухай 182 дугаар конвенцод 2002 онд, Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох Палермогийн протоколд 2008 онд тус тус нэгдэн орсон. Эдгээр олон улсын гэрээ нь улс орнуудыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд болон бэлгийн мөлжлөгийг таслан зогсоох, хохирогч хамгаалал, нөхөн сэргээх арга хэмжээг хойшлуулшгүй авахыг шаарддаг.

Монгол Улсын тухайд сүүлийн жилүүдэд бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэж түүнд насанд хүрээгүй хүн өртөх тохиолдол нэмэгдсээр байна. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тоо мэдээгээр бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн улмаас тус хүрээлэнгээр шинжилгээ хийлгэгчдийн 45.6% буюу 881 нь 0-19 хүртэлх насны хүүхдүүд², 108 хүүхдийн тусламжийн утсанд 2014 онд 46, 2015 онд 131, 2016 онд 169, 2017 оны эхний 5 сарын байдлаар 75 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн дуудлага³ бүртгэгджээ. Энэ бүхэн нь насанд хүрээгүй хүн бэлгийн мөлжлөг, хүчиндэх гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Энэ нь зөвхөн бидэнд мэдэгдэж байгаа тоо мэдээлэл бөгөөд хэрэгсэхгүй болгосон, буцсан, нуугдмал гэмт хэргийн түвшин, тусламж авч чадахгүй хохирогчийг мэдэх, тооцох шаардлагатай.

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой зарим тоо мэдээллээс дурдвал, цагдаагийн байгууллагад сүүлийн 3 жилд 947 буюу ойролцоогоор өдөрт 1 бэлгийн хүчирхийлэл бүртгэгдэж шалгагдсан. Хохирогчдын 80% орчим нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд, 46.8% нь 8-17 насны охид байгаа бөгөөд насанд хүрээгүй хохирогчдын 87 хувь нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчид байна. 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчингийн гэмт хэргийн тоо 30%-иар нэмэгдсэн. Гэвч энэ тоо мэдээ нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийг бүхэлд нь илэрхийлж буй тоо мэдээ биш байх магадлалтай. Ихэнх тохиолдолд хохирогчид хууль хяналтын байгууллагад хандахгүй өнгөрөөдөг, хандсан ч хэрэгсэхгүй болгох, өргөдлөө татаж авах, гомдолгүй, тохиролцсон гэх зэргээр асуудал орхигддог.

- НҮБ-аас 57 оронд хийсэн судалгаагаар⁴ энэ төрлийн гэмт хэргийн 11% нь хуулийн байгууллагад ханддаг гэсэн бол манай улсад үүнийг тооцоолж гаргасан судалгаа одоогийн байдлаар хийгдээгүй байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоо мэдээнээс харахад нийт хүн амын 17%-ийг эзэлж буй 10-29 насны 500 хүн тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн золиос болж байна. ЭМЯ, Глобал

² ЭМЯ, ГС, ХТЭТ. “Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ., 2018. 10-р хуудас.

³ Хөгжлийн академи ТББ. “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан. УБ., 2017. 1-р хуудас.

⁴ UN Women (May 2013). Factsheet - Global, Progress of the World's Women 2011-12 (PDF)

сангийн захиалгаар ХТЭТ-ийн гүйцэтгэсэн 2017 оны судалгааны⁵ үр дүнгээс үзэхэд цагдаагийн байгууллагад хандсан 3 хохирогч тутмын 2 нь шүүхээр асуудлаа эцэслэн шийдвэрлүүлсэн гэжээ. Хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчдын 53.7% нь гэр бүлийн гишүүдээс үйлдсэн хүчиндэх гэмт хэргийн хохирогч болдог ба ихэвчлэн цагдаагийн байгууллагад бүртгэгддэггүй, хүүхэд хохироод л үлддэг асуудал түгээмэл болсон талаарх мэргэжилтнүүдийн бүлгийн ярилцлагаар илэрхийлсэн байдаг.

Иймд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, ялангуяа татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн хэргүүдийг судалж шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх судалгааны ажлыг Монголын Эмэгтэйчүүдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төвөөс захиалж, салбарын мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн багаар “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс (2015-2017)” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгүүлэв.

Зорилго: Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтад нөлөөлж байгаа шалтгаан, хүчин зүйлсийн талаар тоон болон чанарын судалгаа хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны болон эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн үндэслэл бүхий дүгнэлт, санал боловсруулахад оршино.

Зорилт:

- Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаарх статистикт дүн шинжилгээ хийх;
- 2015-2017 онд (хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох) татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн хэргийг судалж, шалтгаан, хүчин зүйлсийг тогтоох;
- Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай гадаадын зарим улсын болон Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид харьцуулсан судалгаа хийж, холбогдох зүйл, заалтыг сайжруулах санал боловсруулах;
- Гадаадын зарим улс орны эрүүгийн хууль тогтоомжид хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын туршлагыг судлах.

Арга зүй: Энэ судалгааг гүйцэтгэхдээ юмс үзэгдлийн хоорондын харилцан хамаарал, шүтэлцээнд нь бодитойгоор судлах боломж олгодог шинжлэх ухааны түгээмэл аргуудыг хэрэглэх ба мэдээ баримтуудыг холбогдох эх сурвалжаас авч, албан ёсны статистик, бодит хэргийн материалд дүн шинжилгээ (задлах, нэгтгэн дүгнэх, харьцуулалт) хийх, ярилцлага,

⁵ ЭМЯ, ГС, ХТЭТ, “Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ., 2018. 10-р хуудас.

ажиглалт, анкетын болон контентын аргыг ашиглав.

Судалгааны ажлыг гүйцэтгэхэд хэрэглэсэн зарим аргыг дурдвал:

- **Тоон судалгааны аргыг ашиглан** Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүсэлт гаргасны дагуу 2018 оны 10 дугаар сард ирүүлсэн 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын гэмт хэргийн мэдээлэлд үндэслэн хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн байдалд математик, статистикийн аргуудыг хууль зүйн шинжлэх ухааны зарим аргатай хослуулан хэрэглэж, дүн шинжилгээ хийлээ.
- **Бодит хэргийг уншиж, дүн шинжилгээ хийх аргыг ашиглан** 2015-2017 онд нийслэлийн хэмжээнд хэрэгсэхгүй болгосон 39 хэргийг уншиж, практикт гарч буй алдаа, дутагдлыг засах, эрх зүйн орчныг сайжруулах саналыг дэвшүүлэв.
- **Харьцуулалтын арга**, хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх аргыг ашиглан олон улсын болон гадаадын зарим улс, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийг авч үзэж, Европын холбоо, Азийн болон Тусгаар тогтносон хамтын нийгэмлэгийн улс орнуудыг төлөөлүүлэн судалгаа, орчуулга хийв.
- **Контент анализын аргаар**, хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн талаар 2015-2017 онд нийтлэгдсэн баримтуудыг сонин, сэтгүүл, нийгмийн сүлжээний цахим болон хэвлэмэл эх сурвалжаас хайлт хийн нийт 85 баримтаас агуулга давхцаагүй, олон уншигч хандсан 31 нийтлэлийг сонгож, дүгнэлт хийв.

Судалгааг ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, түүний Цагдаа судлалын төвийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн баг гүйцэтгэсэн бөгөөд ЦЕГ-ийн харьяа Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мөрдөн байцаах алба болон Хэрэг бүртгэх алба, Үндэсний статистикийн хороо, Эрүүгийн хэргийн төв архив, дүүргүүдийн прокурорын газар дахь эрүүгийн хэргийн салбар архив, ШШҮХ, СЭМҮТ зэрэг байгууллагын дэмжлэгийг авч, хамтран ажиллалаа.

Үр дүн:

Судалгааны үр дүнгээр тайлан гаргах бөгөөд тайланд тусгагдсан санал, зөвлөмжийг төр засгийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргагч болон хэрэгжүүлэгчид хүргүүлснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах ажиллагааны талаар үндэслэл, бүхий оновчтой шийдэлд хүрэхэд чиглэгдэнэ.

Түүнчлэн, хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр үйл ажиллагааны стратеги боловсруулахад чухал хувь нэмрээ оруулна.


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ⁶

Цагдаагийн байгууллагаас жил бүр эрхлэн гаргадаг гэмт хэргийн тухай мэдээллээс үзэхэд бэлгэсийн гэмт хэрэг түүний дотор хүчиндэх, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 30 гаруй хувиар өссөн, харин бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тодруулбал, “хүчиндэх” гэмт хэрэг 2015 онд 279, 2016 онд 290, 2017 онд 376 болж 34.8%-иар өссөн, “арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэмт хэрэг 2015 онд 30, 2016 онд 28, 2017 онд 38 үйлдэн гэмт хэргийн тоо жилд дунджаар 28.6%-иар өссөн, “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэрэг 2015 онд 21, 2016 онд 23, 2017 онуудад 11 үйлдэгдэн гэмт хэргийн тоо өмнөх онуудаас 50%-иар буурсан байна.


График 1. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг бүртгэгдсэн байдал



Хохирогчийн байдлыг авч үзвэл, 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар Хүчиндэх 1417 хэрэгт 1232 хүн холбогдон шалгагдаж, 1382 хүн хохирсны 58 буюу 4.2% нь 7 хүртэлх насны, 233 буюу 16.9% нь 8-13 насны, 384 буюу 27.8% нь 14-17 насны, нийт 675 буюу 48.8% нь хүүхдүүд байна. (График 2)


⁶ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

График 2. Хүчиндэх гэмт хэрэгт хохирсон хүүхдийн насны ангилал




Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 76 бүртгэгдэж, 67 хүн холбогдон шалгагдаж, 73 хүн хохирогч болсны 12 буюу 16.4% нь 7 хүртэлх насны, 26 буюу 35.6% нь 8-13 насны, 6 буюу 8.2% нь 14-17 насны, нийт 44 буюу 60.3% нь хүүхдүүд байна. (График 1.3)

График 3. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт хохирсон хүүхдийн насны ангилал



Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 134 бүртгэгдэж, 119 хүн холбогдон шалгагдаж, 133 хүүхэд хохирогч болсны 17 буюу 12.8% нь 7 хүртэлх насны, 111 буюу 83.5% нь 8-13 насны, 5 буюу 3.8% нь 14-15 насны хүүхдүүд байна. (График 4)


График 4. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт хохирсон хүүхдийн насны ангилал



Дээрх байдлаас дүгнэн үзвэл, **852 хүүхэд** 2015-2017, 2018 оны эхний 10 сарын байдлаар **бэлгийн хүчирхийллийн халдлагад өртжээ.**

Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, хохирогчийг дэлгэрэнгүй авч үзвэл,

График 5. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, хохирогч



Цагдаагийн байгууллагад дээрх хугацаанд бүртгэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаар:

1417 хүчиндэх гэмт хэргийн:

- **65 буюу 4.6%-ийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар,**
- 893 буюу 63.0% -ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж,
- 33 буюу 2.3% -ийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж,
- Одоогийн байдлаар 30.1% буюу 426 (2015 оны 7, 2016 оны 37, 2017 оны 125, 2018 оны 257) эрүүгийн хэргийн шалгалтын ажиллагаа явагдаж байна.


Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 76 гэмт хэргийн:

- **4 буюу 5.3%-ийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар,**
- 57 буюу 75.0% -ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж,
- 1 хэргийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж,
- 18.4% буюу 14 (2016 оны 3, 2017 оны 4, 2018 оны 7) эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна.

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 134 гэмт хэргийн:

- 10 буюу 7.5%-ийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар,
- 88 буюу 65.7%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж,
- 1 хэргийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж,
- 26.1% буюу 35 (2016 оны 5, 2017 оны 14, 2018 оны 16) эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна. (График 6)

График 6. Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн шийдвэрлэлт



	16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (ЭХ-ийн 122/12.5)	Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (ЭХ-ийн 125/12.2)	Хүчиндэх (ЭХ-ийн 126/12.1)
■ Ажиллагаанд	35	14	426
■ Яллах дүгнэлт үйлдэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн	88	57	893
■ Бүртгэгдсэн гэмт хэрэг	134	76	1417
■ Хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн	10	4	65
■ Нэгтгэсэн	1	1	33
■ Түдгэлзүүлсэн			

Цагдаагийн байгууллага 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаар бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн 63.0%-ийг, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн 75.0%-ийг, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн 65.7%-ийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

Энэ хугацаанд бүртгэгдсэн хүчиндэх 65, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 4, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 10, **нийт 79 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн статистик үзүүлэлттэй** (Үндэслэл нь хавтаст хэрэгт хийсэн судалгаагаар тогтоогдож байна.)


1.2. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ⁷

Прокурорын байгууллагаас 2015 онд хүчиндэх 402, 2016 онд энэ тоо буурч, 2017 онд 444 болж, 21.0%-иар өсжээ. 2018 оны эхний 10 сарын байдлаар 948 болж, 2018 оны жилийн эцсээр 2.6 дахин өсөх хандлагатай байна.

2015-2016 онуудад бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 52-63 орчим гэмт хэрэг үйлдэгдсэн байх ба 2018 оны эхний 10 сарын байдлаар буурч 24 болжээ.

2015 онд Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 56 гэмт хэрэг үйлдэгдэж, энэ тоо 2017 он хүртэл буурсан боловч 2018 оны эхний 10 сарын байдлаар 78 болж, өмнөх оноос 70%-иар өсөх хандлагатай байна. (График 7)


График 7. Гэмт хэргийн байдал



Прокурорын байгууллага дээрх хугацаанд бүртгэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт хяналт тавьснаар: 2015-2017, 2018 оны эхний 10 сарын байдлаар хүчиндэх 2161 гэмт хэргийн 916 хэрэг буюу 42.4%-ийг шүүхэд шилжүүлсэн, хэрэг бүртгэлт явуулсан 413, мөрдөн байцаалт явуулсан 10 хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож, 47 хэргийг түдгэлзүүлжээ. (График 8)


⁷ Улсын ерөнхий прокурорын газрын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

График 8. Хүчиндэх гэмт хэргийн шийдвэрлэлт




Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 173 гэмт хэргийн 139 хэрэг буюу 80.3%-ийг шүүхэд шилжүүлсэн нь бусад хэргээс өндөр байна. Хэрэг бүртгэлт явагдсан 10, мөрдөн байцаалт явуулсан 1 хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож, 4 хэргийг түдгэлзүүлжээ. (График 9)

График 9. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шийдвэрлэлт



Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 232 гэмт хэргээс 107 хэрэг буюу 46.1%-ийг шүүхэд шилжүүлсэн, хэрэг бүртгэлт явуулсан 41, мөрдөн байцаалт явуулсан 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийг түдгэлзүүлсэн. (График 10)


График 10. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн шийдвэрлэлт



1.3. ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ⁸

Шүүхээс 2015-2017 онд хүчиндэх 776 эрүүгийн хүлээн авсны 697 буюу 89.8% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 776 эрүүгийн хэргийн 573 буюу **73.8%-ийг шүүхээр шийдвэрлэж**, 665 хүнд ял оноосон байна. (График 11)

График 11. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох эрүүгийн хэргийн шийдвэрлэлт



Шүүхээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 665 шүүгдэгчид ял оногдуулснаас 2015 онд 193, 2016 онд 226, 2017 онд 243 хүнд тус тус хорих ял оногдуулжээ.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 65 хэргийн 60 буюу 92.3% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 65 хэргийн 52 буюу 80.0%-ийг шүүхээр шийдвэрлэж, 55 хүнд ял оноосон байна. Шүүгдэгчдэд ял оноосон байдлыг он дарааллаар авч үзвэл, 2015 онд 18, 2016 онд 19, 2017 онд 18 хүнд тус бүр хорих ял оногдуулсан.

⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 69 эрүүгийн 60 буюу 87.0% нь тухайн тайлант оных байв. Эдгээр 69 эрүүгийн хэргийн 54 буюу 78.3%-ийг шүүхээр шийдвэрлэж, 65 хүнд ял оноосноос 2015 онд 15 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2016 онд 13 хүнд хорих, 8 хүнд албадан ажил хийлгэх, 2017 онд 15 хүнд хорих, 4 хүнд албадан ажил хийлгэх, 2 хүнд торгох ял оногдуулжээ.

Эндээс үзэхэд хүчиндэх гэмт хэрэгт хорих ял оногдуулалт өссөн үзүүлэлт харагдаж байна.

2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргүүдэд нийт 852 хүүхэд хохирсон статистик үзүүлэлт гарч байна.

Прокурор, шүүхэд эдгээр гэмт хэргийн шийдвэрлэлтийн ерөнхий статистик үзүүлэлт гарч байгаа боловч “хүүхэд” өртөж хохирсон талаар нарийвчилсан статистикийн үзүүлэлт гаргахад хүндрэлтэй нөхцөл байдал тулгарч байлаа.

Цаашид ХЗДХЯ-аас хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлсэн “Хууль зүйн цахим нэгтгэл”, “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” мэдээллийн нэгдсэн системийн ашиглалтыг хөгжүүлж, мэдээллийн урсгалыг бүрэн гаргах нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, үйл ажиллагаагаа төлөвлөхөд чухал ач холбогдолтой.

Статистикийн мэдээллийг **“нууцлах бус”**, харин ил тод, нээлттэй байдлыг хангах, эрдэмтэн, судлаачдын эргэлтэнд оруулах нь илүү өгөөжтэй байх болно.

1.4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ:

Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт

(хүчиндэх гэмт хэргийн жишээн дээр)⁹

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүчиндэх гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн **530 хоригдол** байгаа нь нийт ял эдлэгсдийн 15 орчим хувийг эзэлж байна. Тэдгээрээс:

- 0-14 хүртэл буюу бага насны хүүхэд хүчиндсэн 387,
- 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63,
- 18-аас дээш насны хүн хүчиндсэн 80 хоригдол ял эдэлж байна.

Энэ тоо баримтаас үзэхэд хүчиндэх гэмт хэрэг их үйлдэгдэж байгаа нь харагдана.

⁹ ШШГЕГ-ын мэдээлэл. 2018

График 12. 2018 оны байдлаар хүчиндэх гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй нийт хоригдлын тоо, хохирогчдын насны ангилал






График 13. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын нас



Графикаас үзэхэд хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчийн дийлэнх нь 26-41 насны эрэгтэйчүүд эзэлж байгаа бол, нийт хоригдлын 74.9% нь хөдөлмөр эрхэлж байна.

График 14. Хоригдлын хөдөлмөр эрхлэлт




Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 19.4% буюу 103 нь хохирол барагдуулах төлбөрийн өртэй байна.

График 15. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн төлбөртэй хоригдлын тоо



Төлбөртэй хоригдлын төлбөрийн хэмжээ, хохирол нөхөн төлсөн байдлыг авч үзвэл:

График 16. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын төлбөр барагдуулалт



Нийт 37 хоригдлын 58.808.240 төгрөгийн төлбөрийг ар гэрээс нь барагдуулсан бол бусад хоригдлын төлбөрийг барагдуулах зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоригдлыг цалинтай ажлын байраар хангахад анхаарч ирсэн. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4-т заасан “хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх” тухай заалт 2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас хасагдсанаар хоригдлыг хөдөлмөр эрхлүүлж төлбөр барагдуулах ажил үндсэндээ зогссон

НҮБ-аас 1955 онд баталсан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдэд: “Бүх ялтан хоригдлууд... биеийн болон сэтгэл мэдрэлийн онцлогт таарсан хэмжээгээр хөдөлмөрлөх үүрэгтэй гэсэн ч тэдний хөдөлмөр нь нийгэмд болон өөрт нь тустай байх, хоригдлыг ажлын байраар хангах нь юуны өмнө тэднийг хорих газраас суллагдсаны дараа шударга хөдөлмөр эрхлэхэд нь туслах, ур чадварыг бий болгох дээшлүүлэхэд оршино. Хоригдол цалингийн тодорхой хэсгийг ар гэртээ явуулах, хувийн хэрэгцээнд шаардлагатай эд зүйл авахад зарцуулна. Хоригдлын цалингийн

тодорхой хувийг үлдээж хорих ангийн захиргаа хадгалах ба хоригдлыг ял эдэлж дууссан, суллагдах үед түүнд буцааж өгөх ёстой¹⁰ гэсэн заалтыг удирдлага болгон хоригдлыг албадан хөдөлмөрлүүлж учруулсан хохирлыг төлүүлэх заалт хэрэгжихгүй нөхцөл байдал үүссэн байна.

Хоригдлын эрх зүйн байдлыг дээрдүүлэх нь зүйн хэрэг ч хохирогчийн эрх зүйн байдлыг хамгаалах заалтыг орхигдуулахгүй байх нь зүйтэй.

Эрүүгийн хуулийн “Хохирлоо барагдуулсан тохиолдолд хугацааны өмнө суллах” тухай зохицуулалт нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд зохих үр дүнгээ өгч байсан боловч шинээр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиас үзэхэд дээрх заалт хэрэгжих боломжгүй болсон.

Тиймээс шинээр хууль батлан гаргахдаа бусад хуультай уялдаж байгаа эсэхийг анхаарч байх шаардлагатай.

2018 оны байдлаар хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 167 хоригдол суллагдсан, тэдгээрийн 29 нь төлбөртэй байсан бөгөөд 45.9% буюу 14.2 сая төгрөгийн хохирлыг барагдуулж, 54.1% буюу 16.7 сая төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс төлбөртэй хоригдлын төлбөрийг барагдуулах тэднийг цалинтай ажлын байраар хангах зорилгоор тодорхой ажил зохион байгуулж ирсэн боловч хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн үндэс шинээр баталсан хууль тогтоомжоор байхгүй болсон нь хохирогч хохироод үлдэх нөхцөлийг бүрдүүлж байна.


Хүчиндэх гэмт хэргийн хохирогч эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаа, нэр төрөөр давхар хохирдог тул хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох, хоригдлын эрхэлсэн хөдөлмөрийн хөлснөөс хохирол нөхөн барагдуулдаг байх эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй.

¹⁰ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд. НҮБ. 1955. 71 дүгээр зүйл

1.5. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Шүүхийн шинжилгээний байгууллагад хүчиндэх гэмт хэрэгтэй холбоотойгоор “эр эс” илрүүлэх биологийн шинжилгээ 2015 онд 969, 2016 онд 828, 2017 онд 884 удаа хийлгэсний **511 нь хүүхэд** байна.

График 17. Шүүхийн шинжилгээний байгууллагад хүчиндэх гэмт хэрэгтэй холбоотой хийсэн шинжилгээ



Эр эс илрүүлэх биологийн шинжилгээний 2015 онд 67.0%, 2016 онд 89.1%, 2017 онд 91.5%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

График 18. Дээрх шинжилгээнд хамрагдсан хүүхдийн насны байдал¹¹



Эдгээр тоон үзүүлэлт нь биологийн лабораторид хийгдсэн шинжилгээний тоо юм. Үүнээс эр бэлгийн эс илэрсэн эсэхийг гаргах боломжгүй байлаа.


Үүнээс гадна шүүх эмнэлгийн үзлэг хийж заримд нь биологийн шинжилгээ хийдэг. 2015-2017 онд 10-18 насны 67 хүүхдээс эр бэлгийн эс илэрсэн байна.

¹¹ Жич: Тогтоолд нас бичигдээгүй ирүүлдэг тул насыг 0 сонголтоор идэвхжүүлдэг учир 0-1 насны тоог гаргах боломжгүй байна.

Хүснэгт 1. Эр бэлгийн эс илрүүлэх шинжилгээний үзүүлэлт

Он	2015					2016					2017							
	Бүгд	0-1	1-4	5-9	10-14	15-18	Бүгд	0-1	1-4	5-9	10-14	15-18	Бүгд	0-1	1-4	5-9	10-14	15-18
илэрсэн	17	0	0	0	6	11	24	0	0	0	2	22	26	0	0	0	9	17
илрээгүй	218	0	12	31	71	104	199	0	11	35	66	87	269	0	6	24	67	172

График 19. Шүүх эмнэлгийн үзлэг, биологийн шинжилгээгээр эр бэлгийн эс илэрсэн байдал



2015 онд 216 хүүхэд шинжилгээ хийлгэснээс 17, 2016 онд 293 хүүхэд шинжилгээ хийлгэснээс 24, 2017 онд 294 хүүхэд шинжилгээ хийлгэснээс 26, 2018 онд 288 хүүхэд шинжилгээ хийлгэснээс 20, нийт энэ 4 жилд 87 хүүхдийн шинжилгээнээс эр бэлгийн эс илэрсэн байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад **бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсны улмаас хийлгэж буй шинжилгээний бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох, хувь хүний нууцтай холбоотой бус статистик мэдээллийг нээлттэй болгох** нь энэ талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой.

1.6. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2015-2017 онд хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч буюу 0-18 насны **113 хүүхдэд шүүхийн сэтгэц эмгэг судлалын дүгнэлт** гаргасан бөгөөд үүнээс **38 нь сэтгэцийн эмгэгтэй** гэсэн дүгнэлт гарсан байна. Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчийн **44.6% нь** оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой (34.2% нь оюуны хөнгөн хомсдолтой, 5.2% нь оюуны хүндэвтэр хомсдолтой, 5.2% нь төрх үйлийн эмгэгтэй байгаа), **55.4% нь сэтгэцийн хувьд гэмтлийн дараах дасан**

зохицохуйн хямралтай гэж оношлогдсон нь гэмт хэргийн хохирогч болсны улмаас сэтгэцийн эмгэгтэй болсон гэсэн үг.

Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчийн 44.6% нь бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болохоос урьд сэтгэцийн эмгэг (оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдол, төрх үйлийн эмгэг)-тэй байсан.

Дээрх баримт нь “Оюуны хомсдол”-той хүүхдүүдийн хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн анхаарал халамж, хараа хяналт сул байгаагаас үүдэн хүүхдийн эрх ашиг хохирох шалтгаан болж байна.

Ийнхүү сэтгэцийн эмгэгтэй хүүхдүүд олноор гэмт хэргийн золиос болсон байхад хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх гэмт хэрэгт хариуцлага хүлээсэн тохиолдол гараагүй байна.

Иймд сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хуулийн заалтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

Гэмтлийн дараах дасан зохицохуйн хямралтай гэж оношлогдсон хүүхдүүдийн хувьд сэтгэл заслын эмчилгээ зайлшгүй хийх шаардлагатай ч уг эмчилгээ өндөр өртөгтэй ба зардлыг буруутай этгээдээс заавал гаргуулж байх зохицуулалт хэрэгтэй байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд шинжилгээ хийх, төлбөрийн асуудлаар эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зайлшгүй шаардлага байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ҮНДЭСЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

(Нийслэлийн хэмжээнд)

2.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН СУДАЛГАА (2015-2017)

2015-2017 онд Нийслэлийн дүүргийн цагдаагийн хэлтсүүд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч мөрдөн шалгасан хэргүүдэд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тохиолдол байхгүй байна. Зөвхөн 1 гомдолд мөрдөгч, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай санал хүргүүлснийг прокурор эрүүгийн хэрэг үүсгэн, мөрдөн шалгуулахаар буцаажээ.

Нийслэлийн хэмжээнд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг буюу тухайн үед үйлчилж байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн (цаашид “ЭХТА” гэх) 122 (Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх), 125 (Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах), 126 (Хүчиндэх) зүйл, заалтаар зүйлчлэн шалгаж, хэрэгсэхгүй болгосон нийт 39 хэрэг байна. Дээрх хэргүүдийг дүүргээр авч үзвэл:

- Чингэлтэй дүүрэгт - 4;
- Хан-Уул дүүрэгт - 5;
- Баянзүрх дүүрэгт - 14;
- Сүхбаатар дүүрэгт - 5,
- Сонгинохайрхан дүүрэгт - 6;
- Баянгол дүүрэгт - 5 хэрэг оногдож байна.

2015, 2016 онуудад тус бүр 18, 2017 онд 3 хэргийг хэрэгсэхгүй болгосон ба 9 хэргийн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, 1 хэргийн эзэн холбогдогч нь тодорхой ч гадаад улсад зорчсон байхад гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Эдгээр хэрэгсэхгүй болгосон хэргийг Эрүүгийн хуульд заасан зүйл, заалтаар авч үзвэл:

- 1) ЭХТА-ийн 122 дугаар зүйл буюу хохирогчийг 16 насанд хүрээгүйг мэдсээр байж хурьцал үйлдэх гэмт хэрэг Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт тус бүр 1, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт тус тус 2, нийт 6 хэрэг;
- 2) ЭХТА-ийн 125 дугаар зүйл буюу бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэмт хэрэг Хан-Уул, Баянзүрх дүүрэгт тус бүр 1 хэрэг буюу нийслэлийн хэмжээнд нийт 2 хэрэг;
- 3) ЭХТА-ийн 126 дугаар зүйлд заасан хүчиндэх гэмт хэрэг Чингэлтэй дүүрэгт 3, Хан-Уул дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 11, Сүхбаатар дүүрэгт 4, Сонгино хайрхан дүүрэгт 6, Баянгол дүүрэгт 5 гэмт хэрэг нийт 31

гэмт хэрэг үйлдэгдсэнийг хэрэгсэхгүй болгожээ.

Хүчиндэх гэмт хэргийг хуулийн зүйлчлэлийн заалт тус бүрээр нь авч үзвэл:

- a) 126.1. дэх заалтаар зүйлчлэгдсэн хэрэг Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт тус бүр 2, Баянзүрх дүүрэгт 4, Сонгино хайрхан дүүрэгт 1 нийт 9 гэмт хэрэг;
- b) 126 дугаар зүйлийн 126.2 дахь заалтаар зүйлчлэгдсэн гэмт хэрэг Чингэлтэй дүүрэгт 1, Баянзүрх дүүрэгт 4, Сүхбаатар дүүрэгт 3, Сонгино хайрхан дүүрэгт 4, Баянгол дүүрэгт 3 нийт 15 гэмт хэрэг;
- c) 126 дугаар зүйлийн 126.3 дахь заалтаар зүйлчлэгдсэн гэмт хэрэг Баянзүрх дүүрэгт 3, Баянгол дүүрэгт 2, Сүхбаатар, Сонгино хайрхан дүүрэгт тус бүр 1, нийт 7 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаад тус тус хэрэгсэхгүй болгожээ.

Гэмт хэргийн улмаас 40 хүүхэд хохирсон байдлыг хүн ам зүйн шинжээр нь тодорхойлбол:

Хохирогчийн насны байдал:

- 0-13 насны - 6;
- 14-15 насны - 19;
- 16-18 насны - 15 насны хүүхэд байна.

Боловсрол:

- Бүрэн дунд боловсролтой - 1;
- Бүрэн бус дунд боловсролтой - 36;
- Тусгай дунд боловсролтой - 1;
- Бага боловсролтой - 2.

Ажил эрхлэлт:

- Ажилгүй - 1;
- Ажилтай - 2;
- Оюутан - 2,
- Сурагч - 35 байна.

Хохирогчдын оршин сууж буй газраар нь авч үзвэл:

Нийт хохирогчдын 64.7% нь гэр хороололд, 35.3% нь орон сууцны хороололд амьдарч байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл:

- Зочид буудалд 4,
- Такси үйлчилгээнд явдаг хувийн машинд 2,
- Орон сууцны хороололд 6,
- Гэр хороололд 24
- Гэр хорооллын гудамжинд 3 гэмт хэрэг үйлдэгджээ.

Дээрх үзүүлэлтүүд нь хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт аль ч насны хүүхэд өртөж байгааг илтгэхийн зэрэгцээ, нийслэлийн захын гэр хороололд ихээр үйлдэгдэж байгааг харуулж байна.

2.2. ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1) Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаар ирүүлсэн мэдээлэл:

Хэргийн материалаас үзэхэд, уг гэмт хэргийн талаарх мэдээллийг гол төлөв эцэг, эх, төрөл төрөгсөд нь өгдөг ч зарим тохиолдолд хохирогч, түүний ар гэрийнхэн нэр хүндээ бодох эсвэл сургуулиас хасагдаж болзошгүй үр дагаврыг тооцох байдлаар хуулийн байгууллагад ханддаггүй, мөн хохирогчийг буруутгах олон нийтийн хандлага, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогчийн талаарх нууцлалыг хангаж чадахгүй байгаатай холбоотойгоор хуулийн байгууллагад хандах хүсэлгүй, өөр хоорондоо зохицох байдлаар хүүхдийн эрх ашгийг хохироож байна.

2) Хохирогчийн судалгаа

Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн охидын 20% нь үл таних хүнд, 16% нь гэр бүлийн гишүүдэд, 64% нь танил найз, нөхдөдөө хүчиндүүлсэн байна. Тухайлбал:

- 8 охин (15 насны 5, 14 насны 2, 13 насны 1) хүчирхийлэгчтэй нийгмийн сүлжээгээр танилцсан,
- 3 охин (14 насны 3, 15 насны 1) олон нийтийн газарт,
- 12-17 насныхан ихэвчлэн найз нөхдөөрөө дамжуулан хүчирхийлэгчтэй танилцсан, эсвэл нэг хороонд амьдардаг байжээ.
- Хохирогчоор тогтоогдсон хүүхдүүдээс 12 хүүхэд (17 насны 4, 15 насны 4, 14 насны 3, 13 насны 1) нь өмнө нь гэмт этгээдтэй танил төдийгүй, бэлгийн харьцаатай найзууд болох нь мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсон аж.

Харин эцэг эхчүүд хүүхдээ жирэмсэлсэн эсвэл бэлгийн харьцаанд орсон тухай мэдмэгц хохирогч өөрийгөө өмгөөлөх үүднээс ихэвчлэн танихгүй хүнд хүчиндүүлсэн гэж мэдүүлдэг байна.

Дүгнэн үзвэл, өсвөр үеийн охид 13 наснаас, хөвгүүд 15 наснаас бэлгийн харьцаанд орж байгааг анхаарч эцэг эх, сургуулийн эмч, багш, нийгмийн ажилтнууд бэлгийн харилцааны зөв хандлага төлөвшүүлэх талаар зөвлөмж өгч байх шаардлагатай.

3) Гэмт хэрэг үйлдэгчийн судалгаа

Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт нийт 51 хүнийг яллагдагчаар татжээ. Тэдгээрээс дагавар охиноо хүчиндсэн 2, төрсөн охиноо хүчиндсэн 2, завдсан нэг, 2 яллагдагч бэлгийн замаар дамжих халдварт өвчтэй байжээ. Мөн бүлэглэн үйлсэн 7 хэргийн 60%-ийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид үйлдсэн байна. Яллагдагчаар татагдсан этгээдийг:

Насны байдлаар нь авч үзвэл:

- 14-16 насныхан 56.4%;
- 16-18 насны 30%;
- 18-35 насныхан 14%-ийг эзэлж байна.

Боловсролын байдал:

- Дээд боловсролтой - 1;
- Бүрэн дунд боловсролтой - 10;
- Бүрэн бус дунд боловсролтой -32;
- Тусгай дунд боловсролтой - 4 (коллежийн оюутан);
- Бага боловсролтой - 3.

Хөдөлмөр эрхлэлтийн байдал:

- Байнгын ажилтай - 6;
- Хувиараа ажил эрхэлдэг - 4;
- Ажилгүй - 5;
- Оюутан - 7;
- Сурагч - 34 байна.

Дээрх тоо баримтаас үзэхэд бэлгэсийн гэмт хэрэг гарахад боловсрол тодорхой хэмжээгээр нөлөөтэй байгаа бөгөөд хүүхэд, залуус хийх ажилгүй, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх эдийн засгийн боломжгүй, хараа хяналтгүй байдал нөлөөлж байна гэж үзэх үндэслэлтэй.

Хор уршгийн судалгаа

Хохирогчдын хувьд 14 насны 2, 15 насны 3, 16 насны 1 хохирогч гэмт хэргийн улмаас жирэмслэн, үр хөндүүлсэн байх ба жирэмсэлсэн болон сэтгэл зүйн хямралд орсон тохиолдолд нөхөн төлбөр гаргуулахаар нэхэмжлэл гаргаж байжээ. Судалгаанд хамрагдсан хэргээс 3 хохирогч нөхөн төлбөр авчээ.

- 201425005206 дугаартай хэрэгт 8.000.000₮;
- 201525011364 дугаартай хэрэгт 1.055.000₮ нэхэмжилснээс 350.000₮;
- 201525040399 дугаартай хэрэгт 15.000.000₮.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан бусаар хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, яллагдагч хоорондоо тохиролцон, мөнгө хүлээлцэж дараа нь тэр тухайгаа мөрдөгчид тэмдэглүүлэх, мөнгө шилжүүлсэн баримтыг хавтаст хэрэгт хавсаргах, гомдолгүй хэмээн мэдүүлэх байдал эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон хавтаст хэргүүдтэй танилцах явцад ажиглагдлаа.

Шалтгаан:

Хэрэгсэхгүй болгосон хэргүүдтэй танилцах явцад хохирогчдын 25 буюу 36.7% нь өөрийгөө хянах чадваргүй болтлоо согтсоноос бэлгийн хүчирхийлэлд өртсөн, ийнхүү биеэ хянах, хамгаалах чадваргүй болсон

охидын 28% нь 14-16, 16% нь 16-18 насныхан байна.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас гэмт хэргийн золиос болсон шалтгаан нь:

- а) Оюутнууд баяр ёслол, амралтын өдрүүдэд нутаг усаараа, ангиараа нийлэн архидан согтуурч улмаар замбараагүй бэлгийн харьцаанд ордог,
- б) ЕБС-ийн сурагч охид хөвгүүддээ таалагдахын тулд архи уух, бэлгийн харьцаанд ороход бэлэн байх нь элбэг,
- в) Оюутан, сурагчид нийгмийн сүлжээгээр загвар өмсөгч болгоно, кино зураг авалтад оруулна, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэсэн зар, цахим захианд (мессеж) хууртан, зальхай хүмүүсийн хэлсэн бүгдийг хийхэд бэлэн байдаг төдийгүй фэйс бүүк хаягт насаа ахиулан тавьснаас гэмт этгээд, хохирогчийн насанд хүрээгүйг мэдээгүй гэж мэдүүлэх нь цөөнгүй байна.
- д) Үйлчилгээний байгууллагууд 18 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдаалах хориотой журмыг биелүүлдэггүйгээс, ялангуяа ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд согтууруулах ундааны хэрэглээ хэвшмэл шинжтэй болсон. Хэргийн материалаас үзэхэд сурагчид нийлж цугларсан үедээ өөрсдийн гар утас, эд зүйлийг барьцаалан зээлдүүлэх газарт тавин авсан мөнгөөрөө хүртээмжтэйгээр нь том савлагаатай архи, пиво авч хэрэглэх нь түгээмэл байна.

Гэмт хэргийн шийдвэрлэлт:

Нийт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлээр нь авч үзвэл: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1., 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх зүйл буюу гэмт хэрэг үйлдэгдсэн нь тогтоогдоогүй болон яллагдагч эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр нийт хэргийг шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1. буюу “Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болох” тухай заалтаар 1 хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Хэргийн шийдвэрлэсэн байдлыг Эрүүгийн хуульд заасан зүйл, заалтаар:

1. ЭХТА-ийн 122 дугаар зүйлийн 122.1. (16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх) дэх заалтаар 5 хэрэг,
2. ЭХТА-ийн 125 дугаар зүйлийн 125.1. (бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах) дэх заалтаар зүйлчлэгдсэн 2 хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон,
3. ЭХТА-ийн 126 (хүчиндэх) дугаар зүйлээр зүйлчлэгдсэн 31 хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.3., 25

дугаар зүйлийн 25.1-д заасан үндэслэлээр 3 хэрэг, үлдсэн хэргийг 208.1.1.1., 24 дугаар зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгожээ.

Мөн хэргийг мөрдөн шалгах явцад 2 яллагдагчид урьд сонгосон ЭХТА-ийн 126 дугаар зүйлд заасан ялын тогтоолыг хүчингүй болгож шинээр ЭХТА-ийн 122 дугаар зүйлд заасан ялыг сонгосон байна.

2.3. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Зүйлчлэл: Судалгааны явцад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын практикт:

- Илтэд хөнгөн зүйл заалтаар хэргийг хэрэгсэхгүй болгох,
- Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх,
- ЭХТА-ийн 122 дугаар зүйл буюу 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдсэн хэрэгт насанд хүрээгүй хохирогч зөвшөөрсөн эсэхээс үл хамаарч тухайн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай нэгдсэн ойлголтгүйгээс хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй (Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208.1.1., 24.1.1) үндэслэлээр ихэвчлэн хэрэгсэхгүй болгосон байх ба зарим тохиолдолд хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг “Биеийн хөгжлийн хувьд илт бага насны хүүхэд гэж харагдаагүйгээс 16 насанд хүрээгүйг мэдэх боломжгүй байсан” гэсэн нь хууль бус байна.

а) Эрүүгийн хуулийн 126 зүйлийн 2 дахь заалтад: хүчиндэх гэмт хэргийн тухайд: “... насанд хүрээгүй хүнийг...”, 3 дахь хэсэгт: “... хүнд хор уршиг учирсан, бага насны, өөрөөр хэлбэл 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн, үр зулбасан, гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн бол хэмээн хүндрүүлэх нөхцөл байдлыг тогтоосоор байхад энэ зүйл заалтыг хэрэглэхгүй байна.

б) Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад: “Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 нас хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Мөн зүйлийн 2 дахь заалтад: хүчиндэх гэмт хэргийн тухайд: “14-16 хүртэлх насны этгээд энэ хуулийн... 126 (хүчиндэх) ...-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн заалт байсаар байхад практикт огт хэрэглээгүй.

в) Гэмт хэргийн ангиллын тухайд Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд: “Энэ хуулийн тусгай ангид... 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүндэвтэр, 5-аас дээш 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүнд, 10-аас дээш 15 жил онцгой тохиолдолд 25 жил хүртэл хугацаагаар хорих... ял шийтгэхээр заасан гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг”-т хамруулсан ба хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлтэй харьцуулан үзэхэд ЭХТА-ийн 122 зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн бол 3 жил, 125 заасан гэмт хэрэг үйлдсэн бол 5 жил, 126 зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн бол 5 жил, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар дээрх гэмт хэргүүдийг үйлдсэн бол 5-10 жил, 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол 15-25 жил хүртэл

хугацаагаар хорих ял шийтгэхээр заагдсан хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд багтаж байна.

Гэтэл 16 нас хүрээгүй хүн хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг үйлдсэн байхад ихэвчлэн яллагдагч эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй хэмээн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байгаа нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн насанд хүрээгүйтэй холбоотойгоор эрх ашгийг хамгаалах зорилгыг агуулж байх магадлалтай ч, нөгөө талаасаа хууль хэрэгжүүлэгч хуулийг нэг мөр ойлгон биелүүлэх үүргээ ухамсарлахгүй, мөн хуулийн заалтуудын уялдаа холбоог анхаарч үзэхгүй байгаа хандлага ажиглагдаж байна.

Харин хуулийн хувьд гадаадын зарим улс орны Эрүүгийн хуульд яллагдагч нь хохирогчийн насыг андуурч төөрөгдсөн тохиолдолд ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдал гэж үздэг жишгийг судлан үзэх шаардлагатай.

Нотлох баримт: Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт гэрч, хохирогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт голлох нотлох баримт болдог онцлогтой.

Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахдаа хууль зүйн үндэслэлтэй нотлох баримтад тулгуурлаагүй, нотлогдвол зохих нөхцөл байдлыг бүрэн гүйцэт тогтоогоогүй байхад хэргийг хэрэгсэхгүй болгодог байдал нийтлэг байна. Хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж буй субъект нь шийдвэрийг тусгасан баримт бичигт хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг тайлбарлалгүй, зөвхөн зүйл заалтыг тэмдэглэсэн байх жишээтэй. Эрх бүхий субъектийн гаргасан шийдвэр нь ч чухал нотлох баримт болдгийг анхаарах хэрэгтэй.

Мөрдөгчид өөрийн ажилд хайхрамжгүй хандах явдал мэр сэр ажиглагдлаа. Тухайлбал, принтерийн хор нь дууссанаас авсан мэдүүлгүүд нь бараг уншигдахгүй байхад өөрөө болон оролцогчдоор гарын үсэг зуруулсан байна.

Мөрдөн шалгах ажиллагаа: Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэн хэрэгсэхгүй болгосон хавтаст хэргийг судлах явцад хохирогч бэлгийн харьцаанд урьд нь орж байсан эсэх, охин хальс урагдалтай эсэх, бэлгийн замын халдварт өвчинтэй эсэх, тийм өвчин авсан эсэх, жирэмсэн болсон эсэх, сэтгэцийн хувьд өөрчлөлт орсон эсэх, яллагдагчийн хувьд бэлгийн замаар дамжих халдварт өвчтэй эсэх, үр тогтоох чадвартай эсэх болон сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадвартай эсэхийг заавал шинжилгээ томилон шалгуулдаг сайн тал ажиглагдлаа. Гэсэн ч мөрдөн шалгах ажиллагаанд дараах дутагдал оршоор байна:

1) Судалсан хэргийн 80-аад хувьд гэмт хэргийн тухай мэдээллийг ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, өргөдөл, гомдол гаргагчийн тайлбарт үндэслэн, эрүүгийн хэрэг үүсгэсэн байгаа нь эрх бүхий албан тушаалтнууд тухайн үед үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 166 дугаар зүйлийн 166.1. дэх хэсэгт заасан “Гэмт хэрэг гарсныг хангалттай нотлох баримт байвал эрүүгийн хэрэг үүсгэнэ”, мөн хуулийн 172 дугаар зүйлд: “Гэмт

хэргийн талаарх гомдол, мэдээллийг 5 хоногт багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд хугацааг 14 хүртэл хоногоор сунган эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор гэмт хэргийн тоо болон өөрсдийн ажлын ачааллыг механикаар өсгөх үндсэн нөхцөл болсон. Тухайлбал, хэрэгсэхгүй болгосон хавтаст хэргүүд доод тал 50 хуудастай, дээд тал нь 250 хуудастай, зарим нь 250 хуудас бүхий 1-2 хавтастай, 1-2 жил мөрдөн шалгасан хэрэг ч байна.

Энэ байдал нь алба хаагчдын ур чадварыг харуулж байгаа бөгөөд эдийн засаг, цаг хугацааны талаасаа хохиролтой, нөгөө талаас хэргийн оролцогчдыг залхаах, цаг хугацаа, ахуй амьдралыг нь үрсэн ажил болдгийг харуулж байна.

2) Яллагдагч нь тогтоогдоогүй хэргүүдэд ихэвчлэн эрэн сурвалжилсан тухай илтгэх хуудас бичсэнээс өөр зүйл хийсэн нь бага төдийгүй гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдоогүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож буй буруу практик байна.

Энэ бүхэн нь эрх бүхий ажилтнуудын мэдлэг, туршлага чадвартай холбоотой ч, нөгөө талаас ажлын ачаалалд нөлөөлж байна. Учир нь сүүлийн жилүүдэд орон нутгаас хүмүүс олноор нийслэлд шилжин ирж, оршин суугчдын тоо огцом нэмэгдэн, гэмт хэргийн гаралт жилээс жилд өсөж байгаа үед гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүрэг бүхий алба хаагчдын орон тоо дээрх өсөлттэй уялдахгүй байна.

Гэсэн ч хүн бүр хэрэг бүрийн цаана хүүхэд хохирч байгаа гэдгийг анхаарч ажиллах шаардлагатай.

3) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд: “Процессын ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулна” гэж хуульчилсан. Эрүүгийн хэрэгт цугларсан баримт бичгүүд нь төрийн албан бичгийн нэгэн төрөл бөгөөд эрүүгийн процессын ажиллагааны баримт бичгийн бүтэц, түүнд тавигдах шаардлагад нийцсэн байх ёстой. Хавтаст хэргийн баримтаас үзэхэд учир дутагдалтай зүйл нэлээд байна. Тухайлбал, эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлийг болсон баримтыг заах тодорхойлох хэсэгт ор нэр төдий бүрхэг байдлаар бичих буюу үйл явдлыг зөв оноож бичих явдал дутагдалтай, мөрдөгчид хэл зүй, найрлага зүйн мэдлэг тааруу байна.

Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн үйлдлийн арга, гэмт хэрэг гарсан орчин, бага насны хүүхдийн өөрийгөө хамгаалах, илэрхийлэх чадваргүй байдал, хүйсийн онцлог, эцэг эхийн хувийн сонирхол зэргээс шалтгаалан энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа ч өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, мэргэжлийн байгууллагын туслалцаа дэмжлэгт түшиглэсэн, мэргэжлийн ур чадвар шаардсан байдгаас мөрдөгч, прокурор нарт мэргэшүүлэх сургалт явуулах шаардлагатай.

Ийнхүү гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад ихээхэн дутагдал гарч бйагаа нь гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх чиг үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн хүний нөөцийг бэлтгэх байгууллагууд харьяаллын хувьд тусдаа

бие даасантай холбоотойгоор тэдний уялдаа холбоо, хамтын ажиллагаанд доголдол гарч байгаагийн илрэл гэж үзэж байна.

Манай улсын хувьд төрсөн болон хойд эцэг нь хүүхдээ хүчиндсэн, хүчиндэхийг завдсан үед тэднийг тусгаарлах боломж, нөхцөл хангалттай бүрдээгүй, эх нь гэр бүлийн бүрэн бүтэн байдлаа хадгалах, тэжээгчээ алдах, амьжиргааны эх сурвалжгүй болохоос эмээх, зарим нь хэдэн төгрөг авмагц хохирогчийг буруутгах, ятгах, дарамт шахалт үзүүлэх зэргээр хүүхдийн эрх ашгийг зөрчсөн байж болзошгүй байдал ажиглагдлаа. Энэ бүхнээс болж хохирогч анхны мэдүүлгээсээ буцах нь элбэг байна.

Гэр бүлийн гишүүдээс бэлгэсийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хууль ёсны төлөөлөгчөөр холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулах нь илүү үр дүнтэй. Ялангуяа бага насны хүүхэд хохирсон тохиолдолд сэтгэц заслын болон нөхөн сэргээх зэрэг шаардлагатай үйлчилгээнд заавал хамруулж, төлбөрийг буруутай этгээдээс гаргуулж хэвших шаардлагатай.

Насанд хүрээгүй хүүхэд хохирсон хэргийг мөрдөн шалгахдаа “Хохирогч, насанд хүрээгүйн улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдол” хэмээн үзэж хэргийг шүүхээр шийдвэрлүүлж байх хуулийн заалтыг хатуу баримтлах нь зүйтэй.

Зарим хэргийн материалаас үзэхэд эцэг эх хуулиар хүлээсэн асран хамгаалж байгаа хүнээ хараа хяналтгүй байлгасан, хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэсэн тохиолдлуудыг нягтлан шалгахгүй байгаа нь гүтгэсэн байж болох этгээд нь эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй байдагтай холбоотой байна.

2.4. ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХАД ГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛИЙН ТАЛААР МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ ХИЙСЭН БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах хэлтэс, дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн мөрдөгч нартай бэлтгэсэн ерөнхий асуулгын дагуу ярилцлага явууллаа.

Судалгаанд оролцсон алба хаагчдаас ажилласан жилийн талаар сонголт хийхэд ихэвчлэн 1-5 жил ажиллаж байгаа бөгөөд 8-15 жил ажиллаж байгаа мөрдөгч тун цөөн байна.

Мөрдөгчдийн ихэнх нь богино хугацаанд ажиллаж харьцангуй залуу байгаа нь тэдний ажлын туршлага, ур чадвар, мэргэшсэн байдал нь зохих хэмжээгээр хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Энэ дүр зураг аль ч байгууллага дээр ажиглагдсан бөгөөд боловсон хүчний бодлого алдагдсан буюу залгамж чанар алдагдсаны сөрөг үр дагавар ч гэж үзэж болохоор байна.

Дүүргийн цагдаагийн мөрдөгчид энэ төрлийн хэргийн талаарх гомдол

мэдээлэл хүлээн авч эрүүгийн хэрэг үүсгэн хойшлуулшгүй ажиллагаа явуулан, Нийслэлийн цагдаагийн газрын бага насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн хэргийг тусгайлан шалгадаг Мөрдөн шалгах хэлтэст харьяаллын дагуу шилжүүлдэг байна.

Ярилцлагын эхэнд “Та насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг хэдэн удаа шалгасан бэ?” гэсэн асуултад байнга гараад байдаггүй болохоор тэр болгон шалгадаггүй ч ямар нэгэн хэмжээгээр шалгадаг гэж хариулсан.

Энэ төрлийн гэмт хэргийг шалгахад дүүргүүдийн цагдаагийн мөрдөгч нарт хамгийн ихээр тулгардаг хүндрэл, бэрхшээлийг давтагдсан дарааллаар нь гаргахад:

- Мөрдөгч ажлын ачааллаас шалтгаалан хэрэг бүрийг бүрэн гүйцэд шалгах боломж цаг хугацааны хувьд байхгүй нь хэргийг чанартай, бүрэн дүүрэн шалгаж чадахгүй байдалд хүргэдэг;
- Насанд хүрээгүй хохирогч мэдүүлгээ янз бүрээр өгөх, болсон явдлыг бүрэн тодорхойлж чадахгүй байх нь зарим үед гэмт хэрэг гарсан эсэхэд эргэлзээ төрүүлдэг;
- Хэрэг үйлдэгдсэн даруйд мэдэгдэлгүй цаг хугацаа алдсанаас нотлох баримт бүрдүүлэх, шинжилгээ хийхэд хүндрэл учруулдаг;
- Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахад эцэг эхийн нөлөө ихтэй, эцэг эхийнхээ хэлсэн үгээр байдаг, эцэг эх нь холбогдогчоос мөнгө авчихаад мэдүүлгээсээ буцдаг, өөрчилдөг;
- Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчдөд:
- Дүүргийн цагдаагийн хэлтсээс ирүүлж байгаа хэргүүдэд байцаан шийтгэх тодорхой ажиллагаануудыг дутуу, ор нэрийн төдий хийдэг;
- Тодорхой төрлийн гэмт хэрэг шалгах туршлага дутмаг;
- Прокуророос авах зөвшөөрөл ихэссэнээс зөвшөөрөл авах, хэргээ танилцуулах гэж явсаар цаг хугацаа алддаг;
- Шинээр батлагдан мөрдөгдөж байгаа хуульд мөрдөгчийн бие даасан байдлыг ихээхэн хязгаарласан зэрэг нь ажиллахад хүндрэл учруулдаг зэрэг байдлыг дурдаж байв.

Эрүүгийн процессийн ажиллагааны онцлог нь материаллаг болон процессийн хууль тогтоомж, түүний зарчмуудын хэрэгжилт, эдгээр хуулийн шүүхийн өмнөх шатны буюу мөрдөгчийн, прокурорын хууль хэрэглээний алдаа “шүүхийн алдаа” болон өрнөх зүй тогтолтой¹² учраас прокурорын хяналт нь мөрдөгчийн алдааг илрүүлж засах замаар хэрэг дээр алдаатай шийдвэр гарахаас урьдчилан сэргийлэх учиртай.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, албан тушаалтны хувьд хэргийг түргэн шуурхай илрүүлэх, үйл баримтыг зөв тогтоох, эрх зүйн хэм

¹² Ч.Нямсүрэн. Шүүхийн алдааг “тандахуй” /Шудрага ёсны хэмжүүр. Мэдээлэл, хууль зүйн онол практикийн сэтгүүл. 2018.12 сар № 02 /022/. 36 дахь тал

хэмжээг зөв оновчтой хэрэглэх замаар; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг удирдан чиглүүлж байгаа прокурорын хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гүйцэт явагдсан эсэх, нэг талыг барьсан эсэх, ирүүлж буй санал нь хэргийн бодит байдалд нийцсэн эсэх, хууль зүйн үндэслэлтэй эсэх буюу Эрүүгийн процессийн хуулийг ноцтой зөрчсөн эсэх, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн эсэхэд хяналт тавих замаар иргэний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг тус тус хамгаалах учиртай.

2015-2017 онуудад хэрэгсэхгүй болгосон хэргүүдээс үзэхэд нийт шийдвэрлэсэн хэргийн 50 орчим хувьд нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх замаар материаллаг хууль хэрэглээний болон процессийн алдаа гаргажээ. Дээрх албан тушаалтнуудын гаргаж буй шийдвэрүүд нь хэдийгээр хуулийн хүрээнд боловч тогтоосон үйл баримтыг буруу зүйлчлэх эсвэл зүйлчлэлийн үр дагаврыг буруу тодорхойлох замаар үйл ажиллагааны үр дүнгийн баримт болох тогтоолыг батлан гаргах, албан ёсоор хэлбэршүүлэх явцад алдаа гарч байна.

“Алдаа” гэдэг нэр томъёог үйл ажиллагаа болон сэтгэн бодох явцын буруу ташаа байдал¹³ гэж зарим толь бичигт тайлбарласан бол, зарим социологчид: “Гэмт үйлдлийн сэдлийг танин мэдэх, түүнийг зүйлчлэх, шийдвэр гаргах үйл явц буруу байхыг ойлгоно” хэмээжээ.¹⁴

Энэхүү тайлбаруудыг үндэслэвэл, мөрдөгч, прокурорын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх явцад гаргаж буй алдаа нь үйл ажиллагааны болон сэтгэлгээний буюу хуулийг зөрчсөн алдаа, үр дүн нь гэмт хэргийг дахин үйлдэх нөхцлийг бүрдүүлэх магадлал бүхий эрх зүйн сөрөг үр дагавартай.

Эдгээр алдаа нь объектив хүчин зүйл болох хууль тогтоомж боловсронгуй бус, хийдэл ихтэй байх, хуулийг янз бүрээр тайлбарлах, хууль тогтоомжийг хэрэглэх мэдээллийн хомсдол, субъектив хүчин зүйл болох хүний нөөцийн бодлого, ажлын хэт их ачаалал, мэргэшлийн ур чадвар, туршлага дутах зэргээс шалтгаалж байна.

Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нь өвөрмөц онцлог, зүй тогтолтой, нийгмийн бусад үзэгдэлтэй нягт холбоотойгоор үйлдэгддэг бөгөөд нийгмийн хямралын илрэн гарах нэг хэлбэр, сөрөг үзэгдэл мөн.

Дүгнэн үзвэл, холбогдох хууль тогтоомжийн зохицуулалт боловсронгуй бусаас зохиомол, хэт их ачаалал бий болсон; хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй, мэргэшээгүй байдал нь мөрдөгчийг шантраахад хүргэж байна; мөрдөгч, прокурор, шүүгчид төрийн болон хувийн яллах ажиллагааны хэргийн хоорондын ялгааны талаар бүрэн дүүрэн ойлголтгүй, хуулийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

¹³ Ожегов С.И., Шведова Н.Ю. Толковый словарь русского языка. М., 1993. С.501

¹⁴ Карбонье Ж.И. Юридическая социология. М.1986. С.308

Санал:

- 1) Шинэ залуу ажилтныг мэргэшүүлэх сургалт тогтмол зохион байгуулах;
- 2) Эрүүгийн процессын ажиллагаа явуулах эрх бүхий субъектүүдэд хуулийн хэрэглээний талаар ажлын байрны сургалт явуулах,
- 3) Цагдаагийн байгууллага алба хаагчийн ачааллыг тооцож хүний нөөцийг хангалттай хэмжээгээр бүрдүүлэх шаардлагатай.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Бэлгийн эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ялангуяа энэ төрлийн гэмт хэргээс хүүхдийг хамгаалах эрүүгийн эрх зүйн хамгаалалтын талаар гадаад улс орнуудын Эрүүгийн хууль тогтоомжийг харьцуулан судлах нь тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх, хариуцлага хүлээлгэх талаар танин мэдэхээс гадна үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгох чухал ач холбогдолтой.

Бид гадаад улс орнуудын хууль тогтоомжийг харьцуулан судлахдаа эрх зүйн харьцуулсан судалгааны “харьцуулахуй ба эс харьцуулахуйн” аргачлалаар манай улстай харьцуулж болох унитар буюу энгийн төвлөрсөн улсуудын (ОХУ, БНХАУ, БНКУ, БНСУ, Япон улс) хууль тогтоомжийг сонгон авснаас гадна роман-германы буюу эх газрын тогтолцоотой зарим улс орны эрүүгийн хуулиудын зохих зүйл заалтуудын харьцуулалтыг хийлээ.

Эдгээр улс орны Эрүүгийн хууль тогтоомжийг судлахдаа бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болох хүчиндэх, бэлгийн мөлжлөг, хүүхэдтэй хурьцах гэмт хэргийг эрүүжүүлэн (criminalization) ялтай болгосныг (penalization) болон энэ төрлийн гэмт хэргийн хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг ч авч үзлээ.

3.1. МОНГОЛ УЛСЫН 2002, 2015 ОНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Шинээр батлагдсан эрүүгийн багц хууль тогтоомжууд нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны харилцан хамаарал, уялдаа холбоог сайжруулах, нэг стандарт бүхий тогтвортой үйлчлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шинэлэг үзэл баримтлалаар хийсэн боловч олон улсын хүний эрхийн эрх зүйн хамгаалалтын талаарх жишигт нийцээгүй, гадаадын зарим улс орны хуулийн холбогдох заалтыг хэсэгчилэн хуулбарласан, өмнөх хуулиас дордуулсан хууль болсон. Тухайлбал, Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуульд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийг зохих хэмжээнд хуульчилж, хууль хэрэглээний практикт нэгэнт тогтсон байсан. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг тусгайлан бүлэг болгон хуульчилсан ололттой тал байгаа хэдий ч хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шинжийг (бүрэлдэхүүнийг) оновчгүй, тодорхой бус байдлаар хуульчилсан нь хууль хэрэглэхэд ойлгомжгүй байдал бий болгох, ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж байна. Түүнчлэн, УДШ-ээс шинэ

Эрүүгийн хуулийг нэг мөр ойлгон зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргаагүй нь үүнд нөлөөлж байна.

Мөн 2015 оны Эрүүгийн хуульд заасан “Бэлгийн дарамт учруулах” гэмт хэргийг 2017 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болгон, ялангуяа энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр заасныг хүчингүй болгосон нь ухралт болсон билээ.

Харин 2015 оны шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт хүчиндэх гэмт хэргийн шинжийг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдэх аргыг: “хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах” гэж өргөжүүлэн тодотгосон нь практик ач холбогдолтой заалт болсон.

2002 оны Эрүүгийн хуульд: “Хүчиндэх гэмт хэргийг хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол...” гэж заасан байсныг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 12 дугаар зүйлийн 12.1 дэх зүйлд: “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол...” хэмээн өргөжүүлэн бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт хамруулан хуульчилсан нь оновчгүй болжээ. Тухайлбал, Хүчиндэх, бэлгийн харьцааны шинжтэй хүчирхийлэл нь өөр өөр ойлголт. Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт хамруулах нь зохисгүй бөгөөд энэ төрлийн гэмт хэргийг хэт ерөнхийлэн хуульчилсан нь хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд хүндрэл учруулж, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн харилцааны шинжтэй бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэг гэж зүйлчлэх эсвэл зүйлчлэхгүй орших байдлыг бий болгож байна.

2015 оны Эрүүгийн хуулийн 12.2 дугаар зүйлд “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэргийн шинжийг оновчтой бус байдлаар заажээ. “Хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харилцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол...” гэж заасан нь бусад нөхцөлд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасныг гэмт хэрэгт тооцохгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, бэлгийн харилцаанд орохгүйгээр хүнийг айлган сүрдүүлж, хүч хэрэглэхээр заналхийлж эсвэл хуурч мэхлэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хэрхэн зүйлчлэх нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн (үйлдлийн) дунд зай үлдээд бэлгийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл

хийсэн зарим гэмт хэрэгтэнд ял завших боломж бий болж байна. Жишээ нь: эмэгтэй хүнтэй бэлгийн харилцаанд орохгүйгээр хүч хэрэглэн нүцгэн бүжиглүүлж байгаад дур тавих, 2 эмэгтэй хүнийг хүч хэрэглэн эсвэл айлган сүрдүүлж байгаад бэлгийн шинжтэй үйлдэл хийлгэн, уг үйлдлийг харж дур тавьсан этгээд ял зэмгүй үлдэх нөхцөл үүснэ.

Бэлгийн харилцаанд орох, хурьцал үйлдэх гэдэг ойлголт нь өөр өөр бие биеэсээ ялгагдах ойлголт. Хурьцал үйлдэх гэдэг нь эр эмийн ёсоор биологийн хэрэгцээгээ хангах зорилгоор уламжлалт байдлаар бэлгийн ажил үйлдэхийг хэлдэг, бэлгийн харилцаанд орох гэдэг нь уламжлалт болон уламжлалт бус байдлаар харилцан зөвшилцөж хурьцах (лесби, гомосексуалист бусад хэлбэрээр г.м.), бэлгийн ажил үйлдэж биологийн хэрэгцээг хангах явдал мөн. Үүгээр бэлгийн харилцаанд орох гэдэг нь хурьцал үйлдэхээс өргөн хүрээтэй ойлголт болох нь харагдаж байна.

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харилцаанд орох гэмт хэргийн бүрэлдэхүүнийг заахдаа шууд л “бэлгийн харилцаанд орсон” гэж заасан нь уг хэргийг хүчиндэх гэмт хэргээс ялгах боломжийг алдагдуулжээ. Хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харилцаанд орсон, эсвэл хохирогчийн зөвшөөрлөөр хурьцал үйлдсэн нь гэж хуульчилах нь зөв, ийм шинжийг 2002 оны Эрүүгийн хуульд хуульчсан байсан нь оновчтой зохицуулалт байсан юм.

Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг (шинжийг) 2002 оны Эрүүгийн хуульд байснаар 2015 оны шинэчилэн найруулсан Эрүүгийн хуульд хуульчлах шаардлагатай байна.

3.2. ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНТЭЙ БЭЛГИЙН ХАРЬЦААНД ОРОХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд: 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харилцаанд орох үйлдлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээхээр заажээ. Хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол эрүүгийн хариуцлага хүлээнэ. Харин энэ гэмт хэргийн улмаас: 1) хохирогчийг жирэмсэн болгосон; 2) бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол хүндрүүлэхээр заажээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 176 дугаар зүйлд зааснаар 14 нас хүрээгүй этгээдтэй (хүүхэд) бэлгийн харьцаанд орсон буюу түүнд өөртэйгөө бэлгийн харьцаанд орох боломж бүрдүүлсэн этгээд эрүүгийн хариуцлага хүлээдэг. Мөн тийм үйлдлийг гуравдагч этгээдийг буюу гуравдагч этгээдтэй тийм үйлдэл хийх боломжийг бүрдүүлсэн бол ял шийтгэхээр хуульчилсан байна. Харин 1) хүүхдийн дэргэд бэлгийн үйлдэл хийсэн, 2) хүүхдийг бэлгийн үйлдэл хийхэд уруу татсан, 3) хүүхдэд порно зураг, дүрс бичлэг үзүүлэх, порно агуулгатай дуу бичлэг сонсох буюу ярьж өгөх зэргээр хүүхдэд нөлөөлсөн бол хүндрүүлэхээр заажээ. Энэ үйлдэл нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй учраас

төгс үйлдэл шаардахгүй, завдалт хийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хүүхэдтэй ноцтой байдлаар бэлгийн харьцаанд орох (§176a), Хүүхдийн үхэлд хүргэх бэлгийн аюултай үйлдэл (§176b) хийсэн бол мөн хүндрүүлэхээр заасан байна. Үүнд: 1) 18-аас дээш насны этгээд хүүхэдтэй хамтран амьдрах буюу бэлгийн үйлдлийг түүнтэй хийсэн буюу бие махбодод нэвтрэхтэй холбоотой тийм үйлдлийг өөртөө хийх боломж олгосон, 2) үйлдлийг хэд хэдэн этгээдтэй хамтран хийсэн; 3) өөрийн гэмт үйлдлийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүнд гэм хор учруулах буюу түүний бие махбод буюу оюуны хөгжилд хүнд гэм хор учруулах аюул бий болгосон; 4) Сүүлийн 5 жилийн дотор энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлж байсан буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа этгээдэд ял шийтгэнэ. Энэ үйлдлийг порнографийн материал болгон ашиглах зорилгоор гүйцэтгэгч буюу бусад оролцогчийн хувьд оролцсон, уг материалыг тараасан бол хүндрүүлэхээр заажээ. Хэрэв гэмт үйлдлийн үед бие махбодын хүнд гэмтэл учирсан буюу үйлдлийн уршгаар үхэлд хүрэх аюул заналхийлсэн бол онц хүндрүүлэн авч үзэж ял шийтгэнэ. Хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох (§176), Хүүхэдтэй ноцтой байдлаар бэлгийн харьцаанд орох (§176a) гэмт хэргийн улмаас болгоомжгүйгээр хүүхдийг үхэлд хүргэсэн бол бүх насаар нь хорих буюу 10-аас дээш жилээр хорих ял шийтгэнэ. (4) 2 ба 3 дахь заалтад заасан үйлдэлд завдсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 134 дүгээр зүйлд арван зургаан нас хүрээгүй этгээдтэй хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдэл хийх гэмт хэргийг эрүүжүүлжээ. Арван найман нас хүрсэн этгээд нь арван найман нас хүрээгүй этгээдтэй хурьцал үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ. Харин арван найман нас хүрсэн этгээд нь арван найман нас хүрээгүй этгээдийг эрийн эмлэсэн буюу эмийг эм эмлэсэн бол мөн адил хариуцлага хүлээнэ. Арван зургаан нас хүрээгүй этгээдтэй хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдлийг арван хоёр насанд хүрсэн боловч арван дөрвөн насанд хүрээгүй этгээдтэй үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан байна.

Урд өмнө нь насанд хүрээгүй этгээдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн этгээд арван найман нас хүрээгүй этгээдийг эрийг эмлэсэн буюу эмийг эм эмлэсэн бол тусгайлан хүндрүүлэхээр заасан байна.

Хэрэв арван зургаан нас хүрээгүй этгээдтэй хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдэл хийх гэмт хэргийг анх удаа үйлдсэн этгээд нь хохирогчтой гэр бүл болсонтой холбоотойгоор нийгмийн хор аюул арилсан гэж үзвэл шүүх ял шийтгэхээс чөлөөлж болно. Харин хохирогч болон шүүгдэгчийн насны зөрөө дөрвөөс бага бол, 18 насанд хүрээгүй этгээд 16 нас хүрээгүй этгээдтэй хүч хэрэглэхгүйгээр садар самуун үйлдэл хийсэн, хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдэл хийсэн шүүгдэгчид хорих ял шийтгэхгүй.

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 302 дугаар зүйлд: “Бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох, өөрөөр хэлбэл хууран мэхлэх буюу айлган сүрдүүлэх замаар насанд хүрээгүй хүүхэдтэй... хурьцал үйлдсэн буюу садар самуун үйлдэл хийсэн бол ял шийтгэх”-ээр заажээ.

Дани Улсын Эрүүгийн хуулийн 222 дугаар зүйлд зааснаар арван таван нас хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон бол ял шийтгэнэ. Хэрэв хүүхэд 12 нас хүрээгүй буюу гэмт этгээд албадах буюу айлган сүрдүүлэх замаар бэлгийн харьцаанд ороход хүргэсэн бол хүндрүүлэх, мөн хуулийн 223 дугаар зүйлд: “Хэрэв 18 насанд хүрээгүй үрчилж авсан, дагавар хүүхэд, түүнчлэн сургах буюу дасгалжуулахаар итгэж өгсөн хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон, эсхүл нас болон туршлагаар давуу байдлаа ноцтойгоор ашиглаж 18 насанд хүрээгүй этгээдтэй бэлгийн харьцаанд орсон аливаа этгээдэд оногдуулах ялыг хүндрүүлэхээр заасан байна. Мөн хуулийн 223а зүйлд “Биеэ үнэлэх замаар амьдралын эх үүсвэрээ бүрэн буюу хэсэгчлэн хангаж байгаа 18 нас хүрээгүй этгээдтэй үйлчлүүлэгчийн хувьд бэлгийн харьцаанд орсон аливаа этгээдэд ял оногдуулах”-аар заажээ. Харин гэмт этгээд тухайн этгээдийн эрүүл мэндийн байдал, насыг мэдээгүй, хайхрамжгүй хандсан бол уг үйлдлийг санаатай бус гэж үзэж шийтгэлийг тэр хэмжээгээр багасгаж оногдуулна.

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 305 дугаар зүйлд зааснаар насанд хүрээгүй хүүхэдтэй хурьцал үйлдэх буюу садар самуун үйлдэл хийсэн бол эрүүгийн ял шийтгэхээр, Япон Улсын Эрүүгийн хуулийн 176 дугаар зүйлд: “Хүч хэрэглэсэн садар самуун буюу 13 наснаас дээш буюу эрэгтэй, эмэгтэй хүйсийн этгээдийн эсрэг хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самуун үйлдэл хийсэн бол хүнд хөдөлмөр эрхлүүлэн 6 сараас 7 жил хүртэл хугацаагаар хорих ялаар, 13 нас хүрээгүй хүүхэдтэй тийм үйлдэл хийсэн бол ял шийтгэнэ. Япон Улсын Эрүүгийн хуулийн 180 дугаар зүйлд: “Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг зөвхөн хохирогчийн гомдлоор авч хэлэлцэнэ. Уг гэмт хэргийг хоёр ба түүнээс дээш этгээд үйлдсэн бол хохирогчийн гомдолгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэнэ” гэжээ.

БНКУ-ын Эрүүгийн хуулийн 122 зүйлд: “16 нас хүрээгүй этгээдтэй хурьцах буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийх, өөрөөр хэлбэл дурдсан этгээдтэй зориуд санаатайгаар хурьцах, эрийг эмлэх, эмийг эм эмлэх буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийсэн бол ял шийтгэхээр, харин “Бага насны хүүхдийг (бузарлах) садарлах” гэсэн 124 дүгээр зүйл ихээхэн сонирхол татаж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг зориуд санаатайгаар хүч хэрэглэхгүйгээр садарласан бол ял шийтгэнэ. Энэхүү үйлдлийг эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, эсхүл Казакстан Улсын хууль тогтоомжоор түүнийг хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн бусад этгээд үйлдсэн бол хүндрүүлж, энэ үйлдлийг нэг бус удаа үйлдсэн бол онц хүндрүүлэхээр заажээ.

3.3. МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН БЭЛГЭСИЙН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол Улсын болон гадаадын зарим улс орны Эрүүгийн хуульд хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээг харьцуулан үзвэл:

Хүснэгт 2. Ялын харьцуулалт

№		Монгол Улс	ОХУ	ХБНГУ	БНКУ	Франц	Япон	БНСУ	Дани
Хүчиндэх	Ердийн бүрэлдэхүүн					15 жил	2 жилээс дээш		
	Хүндрүүлэх	1-5 жил			15 жил хүртэл	20 жил		3-аас дээш	
	Онц хүндрүүлэх	5-12 жил	8-10 жил		10-15 жил	30 жил		10 жил хүртэл	
	Тусгайлан онц хүндрүүлэх	12-20 Бүх насаар нь хорих	12-20 жил			Бүх насаар хорих	3-аас доошгүй жил		
Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл	Ердийн бүрэлдэхүүн	6 сараас 2 жил				5 жил	2 жилээс дээш		
	Хүндрүүлэх	2-8 жил			8-15 жил	7 жил			
	Онц хүндрүүлэх	5-12 жил	8-15 жил		10-15 жил	10 жил			
	Тусгайлан онц хүндрүүлэх	12-20 жил			15-20 жил Бүх насаар нь хорих				
Бэлгийн албадлага буюу бэлгийн дарамт	Ердийн бүрэлдэхүүн					1 жил			
	Хүндрүүлэх		5 жил хүртэл						
	Онц хүндрүүлэх								
	Тусгайлан онц хүндрүүлэх								

16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	Ердийн бүрэлдэхүүн	6 сараас 1 жил хүртэл	4 жил хүртэл	1 жилээс багагүй	5 жил хүртэл				4 жил хүртэл
	Хүндрүүлэх	6 сараас 3 жил хүртэл	6 жил хүртэл	6 сараас 10 жил (хохилогч 14 нас хүрээгүй)	7-10 жил				6 жил хүртэл
	Онц хүндрүүлэх		8-15 жил	5-аас доошгүй жил	10-15 жил			5 жилээс дээш	10 жил хүртэл
	Тусгайлан онц хүндрүүлэх		12-20 жил Бүх насаар нь хорих	10-аас дээш жил Бүх насаар нь хорих				Бүх насаар нь хорих Цаазаар авах	

Үүнээс үзэхэд ихэнх улс орон хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлд хатуу ял оногдуулах чиг хандлага ажиглагдаж байна. Улс орны эрх зүйн тогтолцооны онцлогоос хамаарч, ял оногдуулах, ялын хэмжээг тогтоох талаар өөр өөрийн гэсэн онцлогтой байна. Тухайлбал, Франц улс хатуу тогтоосон туйлын тодорхой санкцтай бол бусад орон харьцангуй тодорхой санкцтай аж.

Япон, БНСУ зэрэг улс оронд нэмэгдэл ялыг албадан буюу хүнд хөдөлмөр эрхлүүлэн хорихоор буюу мөнгөөр торгох ялыг түлхүү хэрэглэж байгаа бол бусад улс оронд тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эрх чөлөөг хязгаарлах ялыг нэмэгдэл болгон хэрэглэхийн зэрэгцээ торгох ялыг сонгон хэрэглэх боломжтойгоор хуульчилсан байна.

БНСУ, ХБНГУ, Япон Улсын Эрүүгийн хуульд оногдуулах хорих ялыг тодорхойлохдоо хорих ялын доод хэмжээг тогтоож, түүнээс дээш хэдэн жил нэмэгдүүлэн яллах боломжийг шүүхэд олгосон нь сонирхолтой байна.

Харьцуулан судалсан ихэнх улс орны Эрүүгийн хуульд бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг бие даасан бүрэлдэхүүн болгон авч үзэх хандлага хэвээр хадгалагдаж байна. Жишээ нь ОХУ, БНКУ зэрэг улс оронд энэ үйлдэлд эрийг эмлэх (sodomy with men¹⁵), эмийг эм эмлэх (lesbianism) замаар бэлгийн харилцаанд орохыг нарийвчлан хуульчилсан нь хууль хэрэгжүүлэгчид илүү ойлгомжтой хэрэгжүүлэхэд хялбар байна.

ХБНГУ нь зөвхөн насанд хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон төдийгүй бас насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн сэрлийг өдөөж өөртөө болон гуравдагч этгээдтэй бэлгийн харьцаанд орох боломж бүрдүүлснийг гэмт хэрэгт тооцсон, насанд хүрээгүй хүүхдийн дэргэд бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцаанд уруу татсан, порно зураг, дүрс бичлэг үзүүлсэн, порно агуулгатай дуу бичлэг сонсох буюу ярьж өгөх зэргээр хүүхдэд гаж байдлаар нөлөөлсөн бол ял хүндрүүлэхээр хуульчилсан байна.

¹⁵ Sexual intercourse involving anal or oral copulation.

ОХУ-ын Эрүүгийн хуульд зааснаар хохирогч болон шүүгдэгчийн насны зөрөө дөрвөөс бага бол, 18 насанд хүрээгүй этгээд 16 нас хүрээгүй этгээдтэй хүч хэрэглэхгүйгээр садар самуун үйлдэл хийсэн, хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдэл хийсэн бол хорих ял шийтгэхгүй гэж заасан нь онцлог байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд тусгай субъектийг “эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байлгаж байгаа этгээд” гэж тодорхой бус ерөнхий заасан нь “бусад нөхцөл байдал” гэдгийг юу гэж ойлгож тайлбарлаж хэрэглэхэд хүндрэл учирч байна.

ХБНГУ-ын хуульд багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, цагдаа, шүүгч, прокурор, захиргааны болон эрүүгийн процессын бусад хэрэгжүүлэгч, хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хорих байгууллагын ажилтан, сэтгэцийн эмнэлгийн ажилтан, зөвлөгөө өгөх болон үйлчилгээ үзүүлж байгаа ажилтан, багш-дасгалжуулагч зэрэг тусгай субъектийг нарийвчлан хуульчилсан бол Дани Улсын Эрүүгийн хуульд: гяндан, нөхөн сэргээх төв, хүүхдийн асрах газар, сэтгэцийн эмнэлэг, оюуны хомсдолтой хүмүүсийг асрах газар буюу түүнтэй адилтгах газрын дарга, албан хаагчид (§219) гэж тусгайлан заажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд хохирогчийг 14 насанд хүрсэн эсхүл 16 насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан бол, ОХУ, БНКУ-ын хуульд “зориуд санаатайгаар насанд хүрээгүй хүүхэдтэй хурьцал үйлдсэн” гэж оруулсан нь оновчтой болжээ. Харин Дани Улсын хуульд: “Гэмт этгээд тухайн этгээдийн эрүүл мэндийн байдал, насыг мэдээгүй, хайхрамжгүй хандсан бол уг үйлдлийг санаатай бус гэж үзэж шийтгэлийг тэр хэмжээгээр багасгаж оногдуулна” гэж заасан нь объектын андуурлыг харгалзан ял хөнгөрүүлэн авч үзсэн нь оновчтой байна.

ХБНГУ нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг тусгайлан авч хэд хэдэн зүйлд тусгасан нь бусад улс орны хувьд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эрүүгийн эрх зүйн хамгаалалтын сонгодог жишээ болжээ.

ОХУ-д хохирогч болон шүүгдэгчийн насны зөрөө дөрвөөс бага бол, шүүгдэгчид арван найман нас хүрсэн этгээд нь арван найман нас хүрээгүй этгээдтэй хурьцал үйлдсэн (134.1), 18 насанд хүрээгүй этгээд 16 нас хүрээгүй этгээдтэй хүч хэрэглэхгүйгээр садар самуун үйлдэл хийсэн зэрэг үйлдэлд хорих ял шийтгэхгүй гэж заажээ.

Франц Улсын хувьд бие махбодод нэвтрэх гэдгийг “бэлэг эрхтнээр буюу бэлэг эрхтэнд нэвтрэх” гэж ойлгож хэрэглэж байна. Дээрх ойлголтоос гадна гаж дур хүслээ хангахын тулд гадны эд зүйлсээр ам, анус, суга, цавь гэхчлэн бусад эрхтэнд халдах талаар хууль цаазын дүгнэлт өгөөгүй нь учир дутагдалтай байна. Харин Франц Улс хууль ёсны буюу өөрийн төрсөн, жам ёсны буюу босоо шугамын (ойрын цусан болон ясан төрлийн) төрөл садангаас өргөж авсан хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол

онц хүндрүүлэхээр заасан нь оновчтой байна.

Данийн Эрүүгийн хуулийн 223а зүйлд: “Биеэ үнэлэх замаар амьдралын эх үүсвэрээ бүрэн буюу хэсэгчлэн хангаж байгаа 18 нас хүрээгүй этгээдтэй үйлчлүүлэгчийн хувьд бэлгийн харьцаанд орсон аливаа этгээдэд ял оногдуулах”-аар заасан нь ихээхэн сонирхол татаж байгаа юм.

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуульд заасан бэлгийн хүчирхийллийн талаар хуульчилсан байдал учир дутагдалтай байна: Үүнд:

- 1) Бэлгийн дарамт гэсэн гэмт үйлдлийг эрүүгүйжүүлэн (decriminalization) Эрүүгийн хуулиас хассан нь албан тушаалтнуудын энэ бусармаг үйлдлийг өөгшүүлсэн хэрэг болж байна.
- 2) Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъектийг нарийвчлан тодорхойлох, ялангуяа хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг ХБНГУ-ын туршлагаар нарийвчлан хэд хэдэн зүйл, заалтаар хуульчлах шаардлагатай. Тухайлбал, асран хамгаалагч харгалзан дэмжигч давуу байдлаа урвуулан ашиглаж бэлгийн хүчирхийлэл үйлдэх, албаны байдлаа урвуулан ашиглаж (хоригдол, өвчтөн, тусламж хүссэн хүн г.м) бэлгийн хүчирхийлэл үйлдэх буюу бэлгийн дарамт үзүүлэхийг бие даасан бүрэлдэхүүн болгон хуульчилах.
- 3) 18 насанд хүрээгүй биеэ үнэлэгчийг үйлчлүүлэгчийн (клиент) хувиар авсан бол гэмт хэрэгт тооцож ял оногдуулах боломжийг судлах хэрэгтэй.
- 4) Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах гадаад орнуудын ялын бодлого чанга байхад манай улсад доогуур буюу хэт зөөлөн байгаа нь гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлж байж болзошгүй.

ДҮГНЭЛТ

1. Бэлэгсийн гэмт хэрэгт 2015-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар нийт 852 хүүхэд хохирсон. Хүчиндэх гэмт хэрэг 2015-2017 онд жилд дундажаар 34.8%-иар, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 28.6%-иар өссөн, харин бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг өмнөх онуудаас 50%-иар буурсан үзүүлэлттэй байгаа ба хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлддэг гэмт хэргүүдээс хүчиндэх гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдэж, цаашид ч өсөх хандлагатай байна.
2. Улсын хэмжээнд 2015-2017 онуудад үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэргийн 65 буюу 4.6%-ийг, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 76 гэмт хэргийн 4 буюу 5.3%-ийг, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 134 гэмт хэргийн 10 буюу 7.5%-ийг, нийт 79 хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Эдгээрээс нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг буюу 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, хүчиндэх зүйл, заалтаар зүйлчлэгдэн шалгагдаж, хэрэгсэхгүй болгосон нийт 39 хэрэгт байна.

Гэмт хэргийн улмаас 40 хүүхэд хохирсоны 0-13 насны - 6; 14-15 насны - 19; 16-18 насны - 15, тэдгээрийн 35 нь ЕБС-ийн сурагч. Нийт хохирогчийн 64.7% нь гэр хороололд, 35.3% нь орон сууцны хороололд амьдарч байгаа нь бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт аль ч насны хүүхэд өртөж байгааг илтгэхийн зэрэгцээ нийслэлийн захын гэр хороололд энэ төрлийн гэмт хэрэг ихээр гарч байгааг харуулж байна.

Хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлэн хорих ял эдэлж буй 530 хоригдол байгаа нь нийт ял эдлэгсдийн 15 орчим хувийг эзэлж байна. Тэдгээрээс 0-14 хүртэл буюу бага насны хүүхэд хүчиндсэн 387, 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63, 18-аас дээш насны хүн хүчиндсэн 80 хоригдол ял эдэлж байна.

3. 2015 онд 216 хохирогч хүүхэд шинжилгээ хийлгэснээс 14 насны 2, 15 насны 3, 16 насны 1 хохирогч гэмт хэргийн улмаас жирэмслэн, үр хөндүүлсэн, 0-18 насны 113 хохирогчид шүүхийн сэтгэц эмгэг судлалын дүгнэлт гаргуулсан байх бөгөөд 38 хохирогч буюу 44.6% сэтгэцийн эмгэгтэй, 55.4% нь сэтгэцийн гэмтлийн дараах дасан зохицохуйн хямрал буюу гэмт хэргийн хохирогч болсны улмаас сэтгэцийн эмгэгтэй болсон байна.

Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн (эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) анхаарал халамж, хараа хяналт сул байгаагаас үүдэн хүүхдийн эрх ашиг хохирох нэг шалтгаан болж байгаа төдийгүй, хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх зүйл заалтаар нэг ч хүн хариуцлага хүлээлгээгүй байна.

Шүүх шинжилгээний байгууллагад бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсны улмаас шинжилгээ хийлгэж буй хүний бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох, хувь хүний нууцтай холбоотой бус статистик мэдээллийг нээлттэй болгох нь гэмт хэрэгтэй тэмцэх талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд шинжилгээ хийх, төлбөрийн асуудлаар эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зайлшгүй шаардлага байгаа нь ажиглагдлаа.

4. Хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн 80 орчим хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхдээ бүрэн гүйцэт шалгалгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэж байгаа нь нэг талаас энэ төрлийн гэмт хэргийн тоо болон өөрсдийн ажлын ачааллыг механикаар өсгөх үндсэн нөхцөл болж байгаа бол, нөгөө талаасаа ажлын ачаалалд нөлөөлж байна. Учир нь сүүлийн жилүүдэд орон нутгаас хүмүүс олноор нийслэлд шилжин ирж оршин суугчдын тоо огцом нэмэгдэн, гэмт хэргийн гаралт жилээс жилд өсөж байгаа үед гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүрэг бүхий алба хаагчдын орон тоо дээрх өсөлттэй уялдахгүй байна.

Холбогдох хууль тогтоомжийн зохицуулалт боловсронгуй бусаас зохиомол, хэт их ачаалал бий болсон; хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй, мэргэшээгүй байдал нь мөрдөгчийг шантраахад хүргэж байна.

5. Судлагааны явцад хэргийг:

- илтэд хөнгөн зүйл заалтаар зүйлчилж хэргийг хэрэгсэхгүй болгох,
- Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх, хувийн яллах ажиллагааны хэргийн хоорондын ялгааны талаар бүрэн дүүрэн ойлголтгүй, хуулийг бүрэн хэрэгжүүлэхгүй байдал байна.
- 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох хэрэгт, хохирогч зөвшөөрсөн эсэхээс үл хамаарч тухайн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай нэгдсэн ойлголтгүйгээс хохирогч зөвшөөрсөн гэдэг байдлаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгох буруу практик тогтсон байна.

6. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг тусгайлан бүлэг болгон хуульчилсан ололттой тал байгаа хэдий ч хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, гэмт хэргийн шинжийг (бүрэлдэхүүнийг) оновчгүй, тодорхой бус байдлаар хуульчилсан нь хууль хэрэглэхэд ойлгомжгүй байдал бий болгох, ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж байна.

7. Энэ төрлийг гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон тохиолдолд “Хохирогч, насанд хүрээгүйн улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй” тохиолдол хэмээн үзэж хэргийг хэрэгсэхгүй болгохгүйгээр шүүхээр шийдвэрлүүлж байх хуулийн заалтыг хатуу баримтлах нь зүйтэй.

8. Гэр бүлийн гишүүдээс дээрх гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд хууль ёсны төлөөлөгчөөр хүүхэд хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах нь илүү үр дүнтэй
9. Хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4% нь 16-18 насны залуус эзэлж байгаа нь өсвөр үе, залуучуудад чиглэсэн бэлгийн болон ёс зүйн хүмүүжил, хууль, эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалт хийх шаардлагатай байгааг харуулж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг (шинжийг) 2002 оны Эрүүгийн хуульд байснаар 2015 оны шинэчилэн найруулсан Эрүүгийн хуульд хуульчлах;
2. “Бэлгийн дарамт” гэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгож буцаан сэргээх;
3. Хурьцал үйлдэх, бэлгийн харьцаанд орох үйлдлийн ялгааг Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалтад оновчтой хуульчлах;
4. Гадаадын зарим орны Эрүүгийн хуульд заасанчилан хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъектэд оногдуулах ялын бодлогыг чангаруулах;
5. Мөн насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн сэрлийг өдөөх зорилгоор порно агуулгатай бичлэг үзүүлж, сонсгох зэргээр хүүхдэд гаж нөлөөлөн өдөөж өөртэйгээ хурьцах, бэлгийн харилцаанд орох боломж бүрдүүлсэн үйлдлийг эрүүжүүлж, ялтай болгох;
6. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдсэн хэрэгт насанд хүрээгүй хүн зөвшөөрсөн эсэхээс үл хамаарч тухайн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээгэх тухай хуулийн заалтыг чанд мөрдөж хэвших;
7. Хохирлоо барагдуулсан тохиолдолд хугацааны өмнө суллах тухай эрүүгийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх, хүчиндэх гэмт хэргийн хохирогч эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаараа давхар хохирдог тул хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох, хоригдлын эрхэлсэн хөдөлмөрийн хөлснөөс нөхөн барагдуулдаг байх эрх зүйн орчныг бий болгох;
8. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн заалтыг хэрэгжүүлж хэвших;
9. Хүчиндэх гэмт хэргийн хохирлыг тооцдог болон сэтгэл засал, нөхөн сэргээх эмчилгээний зардлыг буруутай этгээдээс гаргуулдаг эрх зүйн механизмыг бий болгох, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо барагдуулаагүй хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн орчныг сэргээх;
10. Бэлгэсийн гэмт хэрэгт хохирогч санал хүсэлтээ илэрхийлж болохоос гадна насанд хүрээгүй хохирогчдын хувьд процессын ажиллагаа ердийн журмаар явагдах хуулийн заалтыг нэг мөр ойлгож, чанд мөрдөж хэвших;
11. Гэр бүлийн гишүүдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хууль ёсны төлөөлөгчөөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн болон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын төлөөллийг оролцуулах;
12. Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгаж байгаа мөрдөгч, прокуроруудад мэргэшүүлэх сургалт болон хуулийн хэрэглээний талаар ажлын байрны

сургалт явуулах;

13. Мөрдөгчийн ажлын ачааллыг тооцож, хүний нөөцийг хангалттай хэмжээгээр бүрдүүлэх;

Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Эцэг эх, сургуулийн эмч, багш, нийгмийн ажилтнууд бэлгийн харилцааны зөв хандлага төлөвшүүлэх талаар хүүхэд, залуучуудад зөвлөгөө өгч байх;
2. Шведийн хөгжлийн талаарх Олон улсын хамтын ажиллагааны (SIDC) Хүн худалдаалахтай тэмцэх стратегийн хүрээнд тус улсын ГЯЯ-аас хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Европын Холбооноос гаргасан зөвлөмжийн дагуу дараах урьдчилан сэргийлэх ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай:
 - Насанд хүрээгүй болон залуучуудад бэлгийн харилцааны талаарх эрүүл ахуйн суртал нэвтрүүлэг хийх;
 - Хүүхэд залуучуудын хүмүүжил, хууль, эрх зүйн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах;
 - Хүүхэд эмэгтэйчүүдийг биеэ үнэлэх болон бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэрт татан оролцуулахтай болон уруу татахтай тэмцэх.
3. Хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4% нь 16-18 насны залуус эзэлж байгаа тул өсвөр үе, залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;
4. Төрийн байгууллагууд хүүхдүүдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдар, оюун санаагаа хөгжүүлэх (спортын секц, дугуйлан, номын сан, уншлагын тэнхим, компьютер бүхий танхим) барилга байгууламжийг олноор бий болгох, ашиглуулах (хүн амын дийлэнх нь амьжиргааны түвшин доогуур байгаагаас төлбөртэй үйлчилгээг авч чаддаггүй);
5. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаараа давхар хохирдог тул хохирлыг тооцдог эрх зүйн механизмыг бий болгох, хоригдлын эрхэлсэн хөдөлмөрийн хөлснөөс нөхөн барагдуулдаг байх эрх зүйн орчныг бий болгох;
6. Шүүхийн шинжилгээний байгууллагад бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсны улмаас хийлгэж буй шинжилгээний бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох, хувь хүний нууцтай холбоотой бус статистик мэдээллийг нээлттэй болгох;
7. Улсын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, тэдгээрийн шийдвэрлэлтийн нэгдсэн статистиктай болох, мэдээ, тайлангийн зөрүүтэй байдлыг арилгах мэдээллийн нэгдмэл байдал, уялдааг хангах, гэмт хэргийн статистик мэдээллийг эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах саналуудыг дэвшүүлж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. НҮБ. 1946;
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. НҮБ. 1946;
3. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц. НҮБ. 1979;
4. Хүүхдийн эрхийн тухай конвенц. НҮБ. 1989;
5. Дэлхий дахины гэмт хэргийн загвар хууль. НҮБ. 2007;
6. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд, НҮБ. 1955;
7. Кибер гэмт хэргийн тухай конвенц. НҮБ. 2001;
8. Монгол Улсын Үндсэн хууль. 1992;
9. Эрүүгийн хууль. 2002, 2015;
10. Зөрчлийн тухай хууль. 2015;
11. Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002;
12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017;
13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017;
14. Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016;

Ном, бүтээл

1. И.Дамбажав нар., Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан Монгол үгийн дээж. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. УБ., 2006. II боть;
2. Жендерийн нэр томьёо, тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ., 2013;
3. Карбонье Ж.И. Юридическая социология. М.1986.
4. Ожегов С.И., Шведова Н.Ю. Толковый словарь русского языка. М., 1993.
5. Ч.Нямсүрэн. Шүүхийн алдааг “тандахуй” //Шудрага ёсны хэмжүүр. Мэдээлэл, хууль зүйн онол практикийн сэтгүүл. 2018.12 сар № 02 /022/.

Судалгааны тайлан

1. “Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. ЭМЯ, ГС, ХТЭТ. УБ., 2018;
2. “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан. Хөгжлийн академи ТББ. УБ., 2017;
3. Б.Энхболд. “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа-2017”. УБ., 2018;
4. “Монгол Улс: Хүн амын дотоодын шилжих хөдөлгөөний судалгаа”. УБ., 2018;
5. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэл - 16, 2017;
6. “Шүүхийн шийдвэрийн шинжилгээ”. эмхэтгэл 1. 2018;

Цахим эх сурвалж

1. [UN Women](#) (May 2013). [Factsheet - Global, Progress of the World's Women 2011-12](#) (PDF);
2. С.Чинзориг. “Жендэрийн тэгш байдлыг хангах нь хөгжлийн үндсэн түлхүүр” нийтлэл // <http://www.mlsp.gov.mn/nnews/242>;
3. Perceptions of precariousness: a qualitative study of constraints underlying gender disparities in Mongolia's labor market // <http://documents.worldbank.org/curated/en>;
4. Мөнхтуяа Ё. Хүний нөөцийн хямрал // <http://tsagtur.mn/>. 2009-09-01-04-10-31 (нийтлэл);
5. <http://www.olloo.mn/n/49403.html>;
6. Д.Баасансүрэн. “Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага: бүхнийг шүүрэгч өргөн хүрээний намаас картель загварт” // Katz, R. *Candling Models of Party Organization and Party Democracy: The Emergence of Cartel Party* / R.Katz, P.Mair // *Party Politics*.-1995.-Vol.1, №1.-P.5-28;
7. Д.Жаргалсайхан. “Монголын нийгмийн бас нэг сорилт: улс төр” нийтлэл // <http://jargaldefacto.com/article/>;
8. <http://1212.mn/BookLibrary>;
9. С.Нарангэрэл. “Монголын хөгжлийн хамгийн том тээг нь бидний ёс суртахууны доройтол” нийтлэл // <https://www.facebook.com/Mongolianlawsociety/>;
10. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны гуравдугаар улирлын үйл ажиллагааны тайлан // police.gov.mn/resource/policegovmn;
11. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд 2017 // <https://ikon.mn/n/1cxa>;
12. <https://www.nso.mn>;
13. <https://news.mn/r/513469/>;
14. <https://www.shuukh.mn>;

Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон бусад байгууллагын албан эх сурвалж

1. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл;
2. Улсын ерөнхий прокурорын газрын мэдээлэл;
3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэл;
4. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн мэдээлэл;
5. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээлэл;
6. Дүүргүүдийн прокурорын газар дахь эрүүгийн хэргийн салбар архивын хавтаст хэргүүд.

Гадаадын зарим улс орны хууль тогтоомж

1. Уголовный кодекс штата Техас. ред. И.Д. Козочкин. "Юрид.центр Пресс"., 2006;
2. Уголовный кодекс Испании. Москва. Зерцало., 1998;
3. Уголовный Кодекс Республики Сан-Марино. "[Юридический центр Пресс](#)", 2003;
4. Уголовный кодекс Франции.Под ред. Л.В. Головки, Н.Е. Крылова. М., 2002;
5. Уголовный кодекс Латвийской Республики. ред., Лукашов А.И., Саркисова Э.А. СПб.:Юридический центр-пресс., 2001;
6. Уголовный кодекс Швейцарии. Перевод с немецкого / Науч. ред.: Серебрянникова А.В. (Пер., предисл.) - С.-Пб.: Юрид. центр Пресс, 2002;
7. Уголовный кодекс Швеции / Науч. ред.: Беляев С.С., Кузнецова Н.Ф. - С.-Пб.: Изд-во "Юрид. центр Пресс", Изд-во Моск. гос. ун-та, 2001;
8. Sokvk skatot Eiropas Padomes Ministru komitejas "Ministru Komitejas Rekomendācija dalībvalstīm R(2000)11 Par cilvēku tirdzniecības seksuālās izmantošanas nolūkā." (IV daļa 23—25.punkts), ko Ministru komiteja pieņēmusi 2000.gada 19.maijā ministru vietnieku sanāksmē;
9. Уголовный кодекс республики Корея.С изменениями и дополнениями на 1 октября 2003 г. Под.ред. А. И. Коробеева. Санкт-Петербург., 2003;
10. Хайонам Мун. Современная ситуация по организованной преступности в Корею // www.crime.vl.ru;
11. Уголовный кодекс Китайской Народной Республики 1997 г // www.legal-way.ru

ХАВСРАЛТ

МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ЭРҮҮЖҮҮЛЖ (CRIMINALIZATION), ЯЛТАЙ БОЛГОСОН (PENALIZATION) БАЙДАЛ

ОХУ, Герман, Франц, Дани, Япон, Монгол, Солонгос, Казакстан улсын насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгосон байдлыг харьцуулан судлахад улс орнуудын үндэсний эрх зүйн тогтолцоо, ёс заншил, амьдралын хэвшил, нийгэм эдийн засаг, соёлын түвшин зэргээс хамаарч өөрийн гэсэн онцлогтой байна. Ялангуяа хууль зүйн техник, соёл, бүтээц (design, construction), бүтэц (structure), эрх зүйн хэм хэмжээг хуулийн зүйл заалтад тусгах арга хэрэгслийн хувьд өвөрмөц онцлогтой байна.

Гадаад улс орнуудын хууль тогтоогчийн хүсэл зориг, нэр томъёог эвдэхгүйг аль болох хичээж, зарим хэллэг, нэр томъёог тухайн улсын ойлголтоор орчуулж, ойлгомжтой болгох үүднээс хууль зүйн монгол хэллэгээр дүйцэх үгийг хаалт дотор дагалдуулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх

1.Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;
/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.2.бүлэглэж;

2.3.гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;

2.4.хохирогчийг жирэмсэн болгож;

2.5.хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;

2.6.хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;

2.7.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

2.8.харгис хэрцгий аргаар;

2.10. хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.

-Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

-“Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно.

12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах

1. Хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг

1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:

2.1. арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;

/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.2. урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

2.3. хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж;

2.4. хохирогчийг жирэмсэн болгож;

2.5. хоёр, түүнээс олон хүний эсрэг;

2.6. байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас:

3.1.ураг зулбасан;

3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:

4.1.бага насны хүүхдийг албадан оруулж;

4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

12.4 дүгээр зүйл. Бэлгийн дарамт учруулах

1.Хохирогчид ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны, бусад байдлаар хохирол учруулах үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэж бэлгийн харьцаанд орох сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл бэлгийн харьцаанд орохыг шаардсан бол нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн, эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохирогчид дарамт учруулж бэлгийн харьцаанд орсон бол нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох

1.Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас:

2.1.хохирогчийг жирэмсэн болгосон¹⁶;

2.2. бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ¹⁷.

¹⁶ /Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

¹⁷ /Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

ОХУ нь 1996 онд баталж, 2018 онд нэмэлт, өөрчлөлт орсон Эрүүгийн хуулийн “Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн 26 дугаар бүлэгт: Хүчиндэх (§131), Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл (§132), Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэлд албадах (§133), 16 насанд хүрээгүй этгээдтэй бэлгийн харьцаанд орох (§134), Садар самуун үйлдэл (§135) зэргийг энэ төрлийн гэмт хэрэгт хамааруулан хуульчилжээ.

Хүчиндэх гэмт хэргийг насанд хүрээгүй буюу 15-18 насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх, хэрэв 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн, урд нь насанд хүрээгүй этгээдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол тус тус онц хүндрүүлэхээр заасан байна.

Зүйл 131. Хүчиндэх

1. Хүчиндэх, өөрөөр хэлбэл, хохирогч болон бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан (далимдуулан) хурьцал үйлдсэн (бэлгийн харьцаанд орсон) бол 3-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Хүчиндэх үйлдлийг:

а) зохион байгуулалттай бүлэг, урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, бүлэглэн үйлдсэн;

б) алахаар буюу эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулахаар заналхийлж, мөн хохирогч буюу бусад этгээдтэй онц хэрцгийгээр харьцаж үйлдсэн;

в) хохирогчид бэлгийн замын (халдварт) өвчин халдаасан бол эрх чөлөөг хоёр жил хүртэл хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр 4-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Хүчиндэх гэмт хэргийг:

а) насанд хүрээгүй хүүхдийг;

б) хохирогчийн бие махбодод болгоомжгүйгээр хүнд хохирол учруулсан, бэлгийн (замын) халдварт (ноцтой, хүнд) өвчин халдаах буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлаж, 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 8-10 жил хүртэл хорих ял шийтгэнэ¹⁸.

4. Хүчиндэх үйлдлийг:

а) хохирогчийг болгоомжгүйгээр алсан;

б) 14 насанд хүрээгүй хохирогчтой (бага насны хүүхдийг хүчиндсэн) үйлдсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлаж, 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 12-20 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

5. Хэрэв энэ зүйлийн дөрөв дэх хэсгийн "б" заалтад заасан үйлдлийг **өмнө нь насанд хүрээгүй этгээдийн бэлгийн халдашгүй байдлын**

¹⁸ (в ред. Федерального закона от 27.12.2009 N 377-ФЗ)

эсрэг гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглон, 15-20 жил хүртэл хорих буюу эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ¹⁹.

Тайлбар: “Хуулийн энэ зүйлийн дөрөв дэх хэсгийн “б” заалт, хуулийн 132 дугаар зүйлийн (Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл) дөрөв дэх хэсгийн “б” заалтад заасан гэмт хэрэгт 134 дүгээр зүйлийн 3-5 дах хэсэг, 135 дугаар зүйлийн 2-4 дэх заалтад заасан **12 нас хүрээгүй**, мөн нас өндөр болсны улмаас биеэ хамгаалах чадваргүй, өөрөөр хэлбэл түүний хийж буй үйлдлийн шинж чанар ач холбогдлыг ойлгох чадваргүй этгээдтэй үйлдсэн үйлдэл мөн хамаарна”²⁰ гэжээ.

Зүйл 132. Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл²¹

1. Хохирогч буюу бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан эрийг эмлэх, эмийг эм эмлэх буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийсэн бол 3-6 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

2. Энэхүү үйлдлийг:

а) зохион байгуулалттай бүлэг, урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, бүлэглэн үйлдсэн;

б) алахаар буюу эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулахаар заналхийлж, мөн хохирогч буюу бусад этгээдтэй онц хэрцгийгээр харьцаж үйлдсэн;

в) хохирогчид бэлгийн (замын халдварт) өвчин халдаасан бол эрх чөлөөг хоёр жил хүртэл хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр 4-10 жил хүртэл хорих ял шийтгэнэ²².

3. Хэрэв энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг:

а) насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн;

б) хохирогчийн бие махбодод болгоомжгүйгээр хүнд хохирол учруулсан, бэлгийн (замын) ноцтой халдварт өвчин халдаах буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлаж, 20 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 8-15 жил хүртэл хорих ял шийтгэнэ²³.

Зүйл 133. Бэлгийн шинжтэй үйлдэлд албадах

1. Далайлган сүрдүүлэх, эд хөрөнгийг нь устгах, гэмтээх буюу авахаар заналхийлэх, эсхүл хохирогчийн эдийн бодон бусад хараат байдлыг далимдуулах замаар эрийг эмлэх (sodomy with men²⁴), эмийг эм эмлэх (lesbianism), бэлгийн харьцаанд орохыг буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэлд албадсан бол 120 мянган рубль буюу гэмт этгээдийн нэг жилийн хөдөлмөрийн хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 480 цагийн

¹⁹ (часть 5 введена Федеральным законом от 29.02.2012 N 14-ФЗ)

²⁰ (примечание введено Федеральным законом от 29.02.2012 N 14-ФЗ)

²¹ (в ред. Федерального закона от 27.07.2009 N 215-ФЗ)

²² (в ред. Федерального закона от 27.12.2009 N 377-ФЗ)

²³ (в ред. Федерального закона от 27.12.2009 N 377-ФЗ)

²⁴ sexual intercourse involving anal or oral copulation

ажил гүйцэтгэх, эсхүл 2 жил хүртэл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 1 жил хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл мөн тийм хугацаагаар хорих ял шийтгэнэ²⁵.

2. Энэхүү үйлдлийг **насанд хүрээгүй этгээдийн эсрэг үйлдсэн** бол 3 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 5 жил хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл 3 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 5 жил хүртэл хорих ял шийтгэнэ²⁶.

Зүйл 134. Арван зургаан нас хүрээгүй этгээдтэй хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдэл хийх²⁷

1. Арван найман нас хүрсэн этгээд нь арван зургаан нас хүрээгүй этгээдтэй хурьцал үйлдсэн бол²⁸ 480 цагийн үүрэгт ажил хийх, эсхүл 4 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлах, эсхүл 3 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 4 жил хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл 10 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 4 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

2. Арван найман нас хүрсэн этгээд нь арван найман нас хүрээгүй этгээдийг эрийн эмлэсэн буюу эмийг эм эмлэсэн бол²⁹ 3 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 5 жил хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл 10 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 6 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг буюу хоёрдугаар хэсэгт заасан үйлдлийг арван хоёр насанд хүрсэн боловч арван дөрвөн насанд хүрээгүй хүүхэдтэй (хүүхдийн эсрэг) үйлдсэн бол 15 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, эрх чөлөөг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр 3-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэхүү зүйлийн нэг, хоёр буюу гуравдугаар хэсэгт заасан үйлдлийг хоёр буюу түүнээс дээш этгээдтэй үйлдсэн бол 20 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, 8-15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5. Энэхүү зүйлийн нэг, хоёр, гурав буюу дөрөвдүгээр хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг, урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, бүлэглэн үйлдсэн бол 20 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, эрх чөлөөг 2 жил хүртэл хязгаарлахгүйгээр 12-20 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

6. Энэ зүйлийн гурав дахь хэсэгт заасан үйлдлийг урд өмнө нь насанд

²⁵ (в ред. Федерального закона от 07.12.2011 N 420-ФЗ)

²⁶ (часть 2 введена Федеральным законом от 29.02.2012 N 14-ФЗ)

²⁷ (в ред. Федерального закона от 29.02.2012 N 14-ФЗ)

²⁸ (в ред. Федерального закона от 28.12.2013 N 380-ФЗ)

²⁹ (в ред. Федерального закона от 28.12.2013 N 380-ФЗ)

хүрээгүй этгээдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол 20 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, эрх чөлөөг 2 жил хүртэл хязгаарлахгүйгээр 12-20 жил хүртэл хорих ял шийтгэх буюу, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар:

1. Хэрэв энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан үйлдлийг анх удаа үйлдсэн этгээд нь хохирогчтой гэр бүл болсонтой холбоотойгоор нийгмийн хор аюул арилсан гэж үзвэл шүүх ял шийтгэхээс чөлөөлж болно.

2. Хэрэв хохирогч болон шүүгдэгчийн **насны зөрөө** дөрвөөс бага бол шүүгдэгчид энэхүү хуулийн 135 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, энэхүү зүйлийн нэг дэх хэсэгт заасан үйлдэлд **хорих ял шийтгэхгүй**.

Зүйл 135. Садар самуун үйлдэл³⁰

1. 18 насанд хүрсэн этгээд 16 нас хүрээгүй этгээдтэй хүч хэрэглэхгүйгээр садар самуун үйлдэл хийсэн бол³¹ 400 цагийн үүрэгт ажил, эсхүл эрх чөлөөг 3 жил хүртэл хязгаарлах, мөн 3 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 5 жил хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл 10 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ³².

2. Энэхүү үйлдлийг арван хоёр насанд хүрсэн боловч арван дөрвөн насанд хүрээгүй этгээдийн эсрэг үйлдсэн бол³³ 15 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, эрх чөлөөг 2 жил хүртэл хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр 3-8 жил хүртэл хорих ял шийтгэнэ³⁴.

3. Энэхүү зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг хоёр буюу түүнээс дээш этгээдийн эсрэг үйлдсэн бол 20 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 5-12 жил хүртэл ял шийтгэнэ.

4. Энэхүү зүйлийн нэг, хоёр буюу гурав дахь хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг, урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, бүлэглэн үйлдсэн³⁵ бол 20 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, эрх чөлөөг 2 жил хүртэл хязгаарлахгүйгээр 7-15 жил хорих ял шийтгэнэ.

5. Энэхүү зүйлийн хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг урд өмнө нь насанд хүрээгүй этгээдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол 20 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглон 10-15 жил хорих ял шийтгэнэ.

³⁰ (в ред. Федерального закона от 27.07.2009 N 215-ФЗ)

³¹ (в ред. Федеральных законов от 29.02.2012 N 14-ФЗ, от 28.12.2013 N 380-ФЗ)

³² (в ред. Федерального закона от 29.02.2012 N 14-ФЗ)

³³ (в ред. Федерального закона от 29.02.2012 N 14-ФЗ)

³⁴ (в ред. Федеральных законов от 27.12.2009 N 377-ФЗ, от 29.02.2012 N 14-ФЗ)

³⁵ (в ред. Федерального закона от 29.02.2012 N 14-ФЗ)

БНКУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС

БНКУ-ын 2014 онд батлагдаж хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт орсон Эрүүгийн хуулийн Тусгай ангийн “Хувь хүний эсрэг эрүүгийн эрх зүйн зөрчил³⁶” гэсэн 1 дүгээр бүлэгт Хүчиндэх (§120), Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл (§121), 16 насанд хүрээгүй этгээдтэй бэлгийн харьцаанд орох буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийх (§122), Бэлгийн (бэлгийн харьцаанд орох) үйлдэл, эрийг эмлэх, эмийг эм эмлэх буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийхийг албадах (§123), Бага насны хүүхдийг бузарлах (§124) зэрэг гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгожээ. Харин гэр бүл хүүхдийн эсрэг эрүүгийн эрх зүйн зөрчил гэсэн 2 дугаар бүлэгт: Бага насны хүүхдийг биеэ үнэлэхэд татан оролцуулах (134), Хүүхдийг эротик агуулгатай бүтээгдэхүүн хийхэд татан оролцуулах (144) зэрэг гэмт хэргийг тусгажээ.

Зүйл 120. Хүчиндэх

1. Хүчиндэх, өөрөөр хэлбэл, хохирогч буюу бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн тусламж авах (биеэ хамгаалах) чадваргүй байдлыг ашиглан (далимдуулан) хурьцал үйлдсэн бол 3-5 таван жил хүртэл хорих ял шийтгэнэ³⁷.

2. Хүчиндэх гэмт хэргийг:

1) зохион байгуулалттай бүлэг, үгсэн тохиролцсон бүлэг этгээд, бүлэглэн үйлдсэн;

2) алахаар заналхийлж, мөн хохирогч буюу бусад этгээдтэй онц хэрцгийгээр харьцаж үйлдсэн;

3) хохирогчид бэлгийн өвчин халдаасан;

4) нэг бус удаа үйлдсэн бол эрх чөлөөг хоёр жил хүртэл хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр дөрвөөс арван жил хорих ял шийтгэнэ.

3. Хэрэв энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг:

1) болгоомжгүйгээр хохирогчийг алсан;

2) болгоомжгүйгээр бие махбодод хүнд гэмтэл учруулсан, бэлгийн (замын) ноцтой халдварт өвчин халдаасан буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн;

3) зориуд санаатайгаар насанд хүрээгүй этгээдийн эсрэг;

4) онцгой нөхцөл байдалд буюу олныг хамарсан үймээн самууныг далимдуулан;

5) эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, эсхүл Казакстан Улсын хууль тогтоомжоор түүнийг хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн бусад этгээд үйлдсэн;

³⁶ Казакстан Улсын Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар эрүүгийн эрх зүйн зөрчлийг нийгмийн хор аюулын зэргээр нь гэмт хэрэг, эрүүгийн зөрчил гэж хоёр ангилна//Ч.Н.

³⁷ См.: Нормативное постановление Верховного Суда Республики Казахстан от 11 мая 2007 года № 4 «О некоторых вопросах квалификации преступлений, связанных с изнасилованием и иными насильственными действиями сексуального характера»

б) (Уг гэмт хэргийг) гэмт бүлэглэл үйлдсэн бол хэрэв 10 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, хэрэв энэ үйлдлийг 5) заалтад заасан этгээд үйлдсэн бол тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг бүх насаар нь хасаж 10-15 жил хорих ял шийтгэнэ.

4. Хэрэв энэ зүйлийн нэг, хоёр болон гурав дахь хэсэгт заасан үйлдлийг илт бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглох бүх насаар нь хасаж 15-20 жил хорих буюу бүх насаар нь хорих ял шийтгэнэ³⁸.

Зүйл 121. Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл

1. Хохирогч буюу бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн аргагүй байдлыг ашиглан (далимдуулан) эрийг эмлэх, эмийг эм эмлэх буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийсэн бол 3-5 жил хорих ял шийтгэнэ.

2. Энэхүү үйлдлийг:

1) зохион байгуулалттай бүлэг, урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, бүлэглэн үйлдсэн;

2) алахаар заналхийлж, мөн хохирогч буюу бусад этгээдтэй онц хэрцгийгээр харьцаж үйлдсэн;

3) хохирогчид бэлгийн (замын) өвчин халдаасан;

4) нэг бус удаа үйлдсэн бол таваас арван жил хорих ял шийтгэнэ.

3. Хэрэв энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг:

а) насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн;

б) хохирогчийн бие махбодод болгоомжгүйгээр хүнд хохирол учруулсан, бэлгийн (замын) ноцтой халдварт өвчин халдах буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлаж, 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 8-15 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

3. Энэхүү зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг:

1) болгоомжгүйгээр хохирогчийг амь насыг хөнөөж;

2) болгоомжгүйгээр бие махбодод хүнд гэмтэл учруулсан, бэлгийн ноцтой халдварт өвчин халдаасан буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн;

3) зориуд санаатайгаар бага насны этгээдийн (хүүхдийн) эсрэг;

4) онцгой нөхцөл байдалд буюу олныг хамарсан үймээн самууныг далимдуулан;

5) эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, эсхүл Казакстан Улсын хууль тогтоомжоор түүнийг (хүүхдийг) хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн бусад этгээд үйлдсэн;

б) Гэмт бүлэглэл үйлдсэн бол 10 жил хүртэл тодорхой албан тушаал, үйл

³⁸ См.: Нормативное постановление Верховного Суда Республики Казахстан от 11 мая 2007 года № 1 «О квалификации некоторых уголовных правонарушений против жизни и здоровья человека»

ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр, хэрэв энэ үйлдлийг 5) заалтад заасан этгээд үйлдсэн бол тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг бүх насаар нь хориглож 10-15 жил хорих ял шийтгэнэ.

4. Хэрэв энэ зүйлийн нэг, хоёр болон гурав дахь хэсэгт заасан үйлдлийг илт бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг бүх насаар нь хориглож 15-20 жил хорих буюу бүх насаар нь хорих ял шийтгэнэ³⁹.

Зүйл 122. Арван зургаан нас хүрээгүй этгээдтэй хурьцах буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийх.

1. Арван зургаан насанд хүрээгүй этгээдтэй зориуд санаатайгаар хурьцах, эрийг эмлэх, эмийг эм эмлэх буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийсэн бол 5 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэхүү үйлдлийг эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, эсхүл Казакстан Улсын хууль тогтоомжоор түүнийг (хүүхдийг) хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн бусад этгээд үйлдсэн бол тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг бүх насаар нь хориглож, 7-10 жил хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг нэг бус удаа үйлдсэн бол тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг бүх насаар нь хориглож, 10-15 жил хорих ял шийтгэнэ⁴⁰.

Зүйл 123. Хурьцах, эрийг эмлэх, эмийг эм эмлэх буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэлд албадах⁴¹

Далайлган сүрдүүлэх, эд хөрөнгийг нь устгах, гэмтээх буюу авахаар заналхийлэх, эсхүл хохирогчийн эд хөрөнгийн болон бусад хараат байдлыг далимдуулах замаар эрийг эмлэх, эмийг эм эмлэх, бэлгийн харьцаанд орохыг буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэлд албадсан бол нэг мянга хүртэл сарын тооцооны үзүүлэлтийн хэмжээгээр торгох, эсхүл мөн тэр хэмжээгээр засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл эрх чөлөөг хязгаарлах, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зүйл 124. Бага насны хүүхдийг (бузарлах) садарлах

1. Бага насны хүүхдийг зориуд санаатайгаар хүч хэрэглэхгүйгээр садарласан бол 7-10 жил тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэхийг хориглож, 5-10 жил хорих ял шийтгэнэ.

2. Энэхүү үйлдлийг эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, эсхүл Казакстан Улсын хууль тогтоомжоор түүнийг (хүүхдийг) хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн бусад этгээд үйлдсэн бол тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг бүх насаар нь хасаж 7-12 жил хорих ял шийтгэнэ.

³⁹ См.: Нормативное постановление Верховного Суда Республики Казахстан от 11 мая 2007 года № 1 «О квалификации некоторых уголовных правонарушений против жизни и здоровья человека»

⁴⁰ См.: Нормативное постановление Верховного Суда Республики Казахстан от 11 мая 2007 года № 4 «О некоторых вопросах квалификации преступлений, связанных с изнасилованием и иными насильственными действиями сексуального характера»

⁴¹ В статью 123 внесены изменения в соответствии с Законом РК от 12.07.18 г. № 180-VI (см. стар. ред.)

3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг нэг бус удаа үйлдсэн бол тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг бүх насаар нь хасаж 10-15 жил хорих ял шийтгэнэ⁴².

ДАНИ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС

Дани Улсын 1997 оны 8 дугаар сард (№648) батлагдаж, 1998, 1999 онд нэмэлт, өөрчлөлт орсон Эрүүгийн хуулийн “Бэлгэсийн гэмт хэрэг” хэмээх 24 дүгээр бүлэгт бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгожээ.

Бүлэг 24: Бэлгэсийн гэмт хэрэг

§216. (1) Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, бэлгийн харьцаанд албадаж буй аливаа этгээдийг хүчиндэх гэмт хэрэгт гэм буруутайд тооцож 6 жил хүртэл (ямар ч) хугацаагаар гянданд хорино. Эсэргүүцэл үзүүлэх (эсэргүүцэх) боломжгүй байдал бий болгосныг хүч хэрэглэсэнд тооцно.

(2) Хэрэв хүчиндэх нь онц аюултай шинжтэй буюу онц хүндрүүлэх нөхцөл байдалд үйлдсэн бол шийтгэлийг арван жилийг хэтрүүлэхгүйгээр гянданд хорих хугацааг хүндрүүлж болно.

§ 217. Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэхээс бусад хууль бусаар албадах өөр арга замаар (Энэ хуулийн 260 дугаар зүйлийн дагуу) бэлгийн харьцаанд орсон аливаа этгээдийг 4 жилээс илүүгүй хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ.

§218. (1) Бусад этгээдийн сэтгэцийн өвчин болон оюуны хомсдолыг ашиглан эдгээр этгээдтэй гэрлэлтээс гадуур бэлгийн ажил хийсэн этгээдийг 4 жил хүртэл хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ.

(2) Тухайн үйлдлийг эсэргүүцэх боломжгүй нөхцөлд байгаа этгээдтэй гэрлэлтээс гадуур бэлгийн ажил хийсэн нь хэрэв Энэ хуулийн 216 дугаар зүйлд заасан шинжгүй бол 4 жилийн хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ.

§219. Гяндан, нөхөн сэргээх төв, хүүхдийн асрах газар, сэтгэцийн эмнэлэг, оюуны хомсдолтой хүмүүсийг асрах газар буюу түүнтэй адилтгах газрын дарга, албан хаагч этгээд нь эдгээр газарт (асран хамгаалалтад нь) байгаа этгээдтэй хурьцал үйлдсэн бол 4 жилээс дээшгүй хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ.

§220. Бусад этгээдийн эдийн засгийн хувьд хараат, захирах захирагдах байдлыг ноцтойгоор ашиглан тухайн этгээдтэй гэрлэлтээс гадуур хурьцсан аливаа этгээдийг нэг жил хүртэл гянданд хорих буюу хэрэв хохирогч 21 нас хүрээгүй бол 3 хүртэл жил гянданд хорих ял шийтгэнэ.

§221. Гэрлэж байна гэх буюу эсхүл өөр хүнтэй хурьцаж байна гэсэн

⁴² См.: Нормативное постановление Верховного Суда Республики Казахстан от 11 мая 2007 года № 4 «О некоторых вопросах квалификации преступлений, связанных с изнасилованием и иными насильственными действиями сексуального характера»

төөрөгдөлд оруулж хуурч мэхлэх замаар хурьцал үйлдсэн аливаа этгээдэд 6 жил хүртэл гянданд хорих ял шийтгэнэ.

§222. (1) Арван таван нас хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон бол 6 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

(2) Хэрэв хүүхэд 12 нас хүрээгүй хүүхэдтэй буюу гэмт этгээд албадах буюу айлган сүрдүүлэх замаар бэлгийн харьцаанд ороход хүргэсэн бол гянданд хорих ялыг 10 жил хүртэл нэмэгдүүлж болно.

§223. (1) Хэрэв 18 насанд хүрээгүй, үрчилж авсан, өргөмөл, дагавар хүүхэд, сургах буюу дасгалжуулахаар итгэж өгсөн хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон аливаа этгээдийг 4 жил хүртэл хугацаагаар гянданд хорих ял шийтгэнэ.

(2) Нас болон туршлагаар давуу байдлаа ноцтойгоор ашиглаж 18 насанд хүрээгүй этгээдтэй бэлгийн харьцаанд орсон аливаа этгээдэд мөн адил ял шийтгэнэ.

§223а. Биеэ үнэлэх замаар амьдралын эх үүсвэрээ бүрэн буюу хэсэгчлэн хангаж байгаа 18 нас хүрээгүй этгээдтэй үйлчлүүлэгчийн хувьд бэлгийн харьцаанд орсон аливаа этгээдийг торгох буюу энгийнээр баривчлах буюу хоёр жилээс хэтрүүлэхгүйгээр гянданд хорих ял шийтгэнэ.

§224. Энэхүү хууль болон 216-223а зүйлийн үндэслэлийг хурьцахаас өөр бэлгийн бусад харилцаанд мөн адил хэрэглэнэ.

§225. Хуулийн 216-220 болон 222-223 зүйлүүдийн үндэслэлийг аль ч хүйсийн этгээдэд хэрэглэнэ.

§226. Хэрэв дээр дурдсан нөхцөл байдалд шийтгэлийн мөн чанар нь сэтгэцийн болон бие махбодын хэвийн бус байдал, нас зэргээс шалтгаалах учир, гэмт этгээд тухайн этгээдийн эрүүл мэндийн байдал, насыг мэдээгүй, хайхрамжгүй хандсан бол уг үйлдлийг санаатай бус гэж үзэж шийтгэлийг тэр хэмжээгээр багасгаж оногдуулна.

§227. Хэрэв 216-224 буюу 226 зүйлд заасан үйлдэл хийсэн этгээд нь зөвшөөрөлгүйгээр бэлгийн харьцаанд орсон этгээдтэйгээ гэрлэсэн бол ялаас чөлөөлнө.

§228. (1) Аливаа этгээд:

1) бусдыг зүй бусаар бусад этгээдтэй бэлгийн харилцаанд орж орлого олоход уруу татсан буюу

2) ашиг олох зорилгоор бусад этгээдийг гуравдагч этгээдтэй зүй бусаар бэлгийн харьцаанд оруулахаар шилжүүлсэн буюу өөр этгээдтэй бэлгийн зүй бус (ёс суртахуунгүй) харьцаанд орсон этгээдийг энэ үйл ажиллагаагаа орхих боломж олгоогүй буюу

3) бордель (бие үнэлэх байр) ажиллуулсан (агуулсан);

Бие үнэлэхэд уруу татсан гэм буруутай этгээдийг дөрвөн жилээс дээшгүй хугацаагаар гянданд хорино.

(2) Мөн 21 нас хүрээгүй этгээдэд бэлгийн зүй бус харьцааг мэргэжлийн

үйл ажиллагааны хувьд эрхлэхэд уруу татсан, тусалсан, 21 нас хүрээгүй буюу энэ талаар мэдээгүй байсан этгээдийг хилийн цаана бэлгийн ёс бус харьцааг мэргэжлийн үйл ажиллагааны хувьд эрхлүүлэх зорилгоор эх орноо орхихыг ятгасан этгээдэд ял шийтгэнэ.

§229. (1) Ашиг олох зорилгоор, зуучлагчаар, бэлгийн ёс бус харьцаанд байнга давтан оролцсон, мэргэжлийн үйл ажиллагааны хувьд бэлгийн ёс бус харьцаанд ордог ямар ч этгээдийн үйл ажиллагаанаас орлого олдог аливаа этгээдийг гурван жилээс илүүгүй хугацаагаар хорих, хөнгөрүүлэх нөхцөл байдалтай бол энгийнээр хорих буюу торгох ял шийтгэнэ.

(2) Мэргэжлийн үйл ажиллагааны хувьд бие үнэлэхийг эрхлэх зорилгоор зочид буудал буюу дэн буудалд өрөө гаргаж өгсөн этгээдэд энгийнээр хорих (баривчлах) буюу нэг жилээс хэтрүүлэхгүйгээр хорих буюу хөнгөрүүлэх нөхцөл байдалтай бол торгох ял шийтгэнэ.

ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

ХБНГУ 2016 онд “Бэлгийн халдашгүй байдлын хамгаалалтыг сайжруулах тухай 463/19 хууль⁴³”-ийг батлан гаргаж одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн нэг онцлог нь асран хамгаалагч харгалзан дэмжигч нар давуу байдлаа урвуулан ашиглаж бэлгийн хүчирхийлэл үйлдэх, хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох, албаны байдлаа урвуулан ашиглаж бэлгийн үйлдэл хийх буюу бэлгийн дарамт үзүүлэхийг бие даасан бүрэлдэхүүн болгон хуульчилсанд оршино.

2016 оны хуулиар гадаадын дүрвэгч цагаачдын урсгал, араб, африкийн цагаачдын үйлдэж буй хүчиндэх гэмт хэрэг байнга үйлдэх болсонтой холбоотойгоор “Үгүй л гэсэн бол үгүй” (No means no) гэсэн компани ажлын хүрээнд хохирогч хэдийгээр биеийн хүчээр эсэргүүцэл үзүүлээгүй боловч, бэлгийн харьцаанд орох хүсэлгүйгээ илэрхийлсэн л бол хүчиндэх гэмт хэрэг үйлдсэнд тооцохоор хууль зүйн хариуцлагыг чангатгасан байна.

Эрүүгийн хуульд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн субъектийг өргөжүүлж, зарим үйлдэлд ногдуулах хариуцлагыг чангатгасан буюу шинээр эрүүжүүлсэн байна. Жишээ нь Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлийг (Эсэргүүцэл үзүүлэх (биеэ хамгаалах) чадваргүй этгээдтэй бэлгийн үйлдэл хийх) хүчингүй болгож, 177 болон 178 дугаар зүйлийг өөрчлөн томьёолж, нэмэлт, өөрчлөлт оруулж, 184 дүгээр зүйлд Бэлгийн албадлага (*Nötigung*), “садар самуун үйлдэл” (*sexueller Missbrauch*) зэрэг нэр томьёоны зэрэгцээ шинээр бэлгийн дарамт (*sexuelle Belästigung*) үзүүлсэн бол 2 жил хүртэл хорих ял оногдуулахаар заажээ.

Иймээс хүчиндэх, өөрөөр хэлбэл хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулахаас гадна хохирогчийн зөвшөөрөөгүй үед хийсэн үйлдэл мөн

⁴³ Gesetz zur Änderung des Strafgesetzbuches - Verbesserung des Schutzes der sexuellen Selbstbestimmung. Drucksache 463/16 02.09.2016

хамаарах болжээ.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн, завдсан бол хамтран оролцсон бүх этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээр болсон байна.

Бүлэг XIII. §174. Асран хамгаалах эрхээ урвуулан бэлгийн хүчирхийлэл үйлдэх

(1) Хэн нэгэн (аливаа этгээд) нь бэлгийн үйлдлийг дараах этгээдийн эсрэг үйлдсэн:

1. асран хамгаалуулах буюу хүмүүжүүлэх, боловсрол олгохоор итгэн хариуцуулсан, арван зургаан нас хүрээгүй этгээд,

2. ажлын буюу албаны харилцааны хүрээнд захиргаанд нь байгаа буюу түүнд хүмүүжүүлэх, боловсрол олгохоор итгэн хариуцуулсан, асран хамгаалуулсан арван найман нас хүрээгүй этгээдийг хүмүүжүүлэх, боловсрол олгох, харгалзан дэмжих, албаны болон ажлын харилцааны хараат байдлыг далимдуулсан буюу

3. өөрийн цусан төрлийн, үрчилж авсан 18 нас хүрээгүй хүнтэй буюу асран хамгаалуулагчийг өөртэйгөө тийм үйлдлийг хийхийг зөвшөөрсөн бол 5 жил хүртэл хорих буюу мөнгөөр торгох шийтгэл оногдуулна.

(2) Хэн нэгэн энэ зүйлийн 1 дэх хэсэг, 1-3 дахь заалтад заасан үйлдлийг

1. асран хамгаалагчийн дэргэд бэлгийн үйлдэл хийсэн буюу

2. өөрөө болон асран хамгаалагчийг өдөөхийн тулд түүний дэргэд бэлгийн үйлдэл хийхээр уруу татсан бол 3 жил хүртэл хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(3) (гэмт үйлдэл хийхээр) завдсан бол шийтгэнэ.

(4) Зүйлийн 1 дэх хэсэг, 1 дэх заалт буюу 2 дахь хэсгийг 1 дэх хэсэг, 1 дэх заалтыг тооцох үндсэн дээр шүүх асран хамгаалагчийн зан үйл, үйлдлийн ялимгүй шинжийг харгалзан яллахаас татгалзаж болно.

§174а. Хоригдол, захиргааны журмаар баривчлагдсан этгээд буюу өвчтөн болон зохих байгууллагад тусламж эрсэн этгээдтэй бэлгийн үйлдэл хийх.

(1) хоригдол буюу түүнд хүмүүжүүлэх, сургах буюу халамж үйлчилгээ үзүүлэхээр итгэмжлэн хариуцуулж түүнд захиргааны хяналт тавих үүрэгтэй хэн нэгэн (этгээд) өөрийн давуу байдлаа ашиглан бэлгийн ажил хийсэн, хоригдол буюу асран хамгаалагчийг өөртөө тийм үйлдэл хийхийг зөвшөөрсөн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(2) Эмнэлэг, тусламж үзүүлэх болон хяналт тавих байгууллагад байгаа этгээдийн өвчин болон тусламжгүй байдлыг далимдуулан бэлгийн үйлдэл хийсэн буюу тэдгээрийг өөртөө тийм үйлдэл хийх боломж олгосон бол мөн адил шийтгэнэ.

(3) Завдалт шийтгэлтэй.

§174b. Албаны байдлаа ашиглан бэлгийн үйлдэл хийх

(1) Хэн нэгэн (аливаа этгээд) эрүүгийн процесс буюу тусгаарлахтай холбоотойгоор аюулгүй байдлыг хангах, засан хүмүүжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх процесс буюу захиргааны журмаар баривчлахтай холбоотой процессыг хэрэгжүүлэхээр томилогдсон албан тушаалтны хувьд процессын ажиллагаатай холбогдон тухайн этгээдийн хараат байдлыг урвуулан ашиглаж түүнтэй бэлгийн үйлдэл хийсэн буюу тэдгээрийг өөртэйгөө хийх боломж олгосон бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(2) Завдалт шийтгэлтэй

§174c. Зөвлөгөө өгөх, эмчлэх буюу үйлчилгээний харилцааг ашиглан бэлгийн үйлдэл хийх

(1) Хэн нэгэн (аливаа этгээд) түүнд зөвлөгөө өгөх, эмчлэх, халамж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор итгэмжлэн хариуцуулсан оюуны хомсдол буюу сэтгэцийн өвчин буюу түүний дотор сэтгэцийн хямрал зэрэг гажуудалтай этгээдтэй зөвлөгөө өгөх, эмчлэх буюу халамж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаагаа урвуулан ашиглаж бэлгийн үйлдэл хийсэн, өөртөө хийх боломж бүрдүүлсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(2) Мөн сэтгэцийн гэмтлийг (эмгэгийг) эмчлэхээр итгэмжлэн хариуцсан этгээд “эмч-үйлчлүүлэгч”-ийн харилцааг урвуулан ашиглаж, бусадтай бэлгийн үйлдэл хийсэн буюу, өөртөө хийх боломж бүрдүүлсэн бол мөн адил шийтгэнэ.

(3) Завдалт шийтгэлтэй.

§175. (хүчингүй болсон)

§176. Хүүхэдтэй бэлгийн үйлдэл (хурьцах) хийх. (1) Хэн нэгэн 14 нас хүрээгүй этгээдтэй (хүүхэд) бэлгийн үйлдэл хийсэн буюу түүнд өөртэйгөө хийх боломж бүрдүүлсэн бол 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар, харгалзан (хөнгөрүүлэн) үзэх тохиолдолд 5 жил хүртэл хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(2) хүүхэд гуравдагч этгээдтэй бэлгийн үйлдэл хийх буюу гуравдагч этгээд өөртэй нь тийм үйлдлийг хийх боломж бүрүүлэхэд уруу татсан бол мөн тийм шийтгэл хүлээнэ.

(3) Таван жил хүртэл хорих буюу мөнгөн торгуулиар дараах этгээдэд ял шийтгэнэ

1. хүүхдийн дэргэд бэлгийн үйлдэл хийсэн,

2. хүүхдийг бэлгийн үйлдэл хийхэд уруу татсан буюу

3. хүүхдэд порно зураг, дүрс бичлэг үзүүлэх, порно агуулгатай дуу бичлэг сонсох буюу ярьж өгөх зэргээр нөлөөлөх.

(4) Завдалт шийтгэлтэй. Энэ хэм хэмжээ нь 3 дугаар хэсгийн 3 дахь заалтад заасан үйлдэлд хамаарахгүй.

§176а. Хүүхэдтэй ноцтой байдлаар бэлгийн харьцаанд орох

(1) Хуулийн § 176 зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан үйлдлийг хүүхдийн эсрэг хийсэн бол нэгээс багагүй хугацаанд хорих ял шийтгэнэ, хэрвээ

1. 18-аас дээш насны этгээд хүүхэдтэй хамтран амьдрах буюу бэлгийн үйлдлийг түүнтэй хийсэн буюу бие махбодод нэвтрэхтэй⁴⁴ холбоотой тийм үйлдлийг өөртөө хийх боломж олгосон буюу;

2. Үйлдлийг хэд хэдэн этгээдтэй хамтран (бүлэглэн) хийсэн,

3. Аливаа этгээд өөрийн гэмт үйлдлийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүнд гэм хор учруулах буюу түүний бие махбод буюу оюуны хөгжилд хүнд гэм хор учруулах аюул бий болгосон буюу;

4. Сүүлийн 5 жилийн дотор энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлж байсан буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа.

(2) §176-ийн 1-4 хэсэгт заасан үйлдлийг порнографийн материал болгон ашиглах зорилгоор гүйцэтгэгч буюу бусад оролцогчийн хувьд оролцсон тохиолдолд, мөн §184-ийн 3 буюу 4 дэх хэсгийн агуулгаар⁴⁵ тараасан тохиолдолд 2 жилээс багагүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(3) 1 дэх хэсгийн хүнд тохиолдолд 3 сараас 5 жил хүртэл хорих, 2 дахь хэсгийн илүү хүнд тохиолдолд нэг жилээс 10 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

(4) §176-ийн 1 ба 2 хэсэгт заасан этгээдэд 5-аас доошгүй хорих ял шийтгэнэ, хэрэв хүүхдэд

1. гэмт үйлдлийн үед бие махбодын хүнд гэмтэл учирсан буюу

2. үйлдлийн уршгаар үхэлд хүрэх аюул заналхийлсэн бол.

§176б. Хүүхдийн үхэлд хүргэх бэлгийн аюултай үйлдэл

Хэрэв аливаа этгээд бэлгийн үйлдлийн (§§176 болон 176а) улмаас гэнэн хөнгөмсөг байдлаар (хөнгөмсгөөр найдах буюу хайхрамжгүй хандаж) хүүхдэд үхэлд хүргэсэн бол бүх насаар нь хорих буюу 10-аас дээш жилээр хорих ял шийтгэнэ.

§180. Бага насны хүүхэдтэй бэлгийн үйлдэлд хамтрах

(1) Хэн нэгэн (аливаа этгээд) 16 насанд хүрээгүй этгээд гуравдагч этгээдтэй бэлгийн үйлдэл хийхэд хамтран оролцсон буюу түүний дэргэд (3 этгээдтэй) тийм үйлдэл хийсэн буюу гуравдагч этгээд 16 насанд хүрээгүй хүүхэдтэй бэлгийн үйлдэл хийхэд

1. зуучилсан буюу

2. зөвшөөрөх буюу хийх нөхцөлийг нь бүрдүүлсэн бол 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

1 дэх хэсгийн 2 дахь заалтыг бага насны хүүхдийг асран хамгаалах эрх бүхий этгээд үйлдсэн бол хэрэглэхгүй. Энэ үндэслэл нь мөн зуучлах замаар өөрт нь итгэмжлэн хүмүүжүүлэхээр өгсөн бүрэн эрх бүхий этгээд үйлдсэн бол үйлчлэхгүй.

⁴⁴ Франц, Герман зэрэг улсын эрүүгийн хуульд ийм нэр томъёо хэрэглэж байна. //Өмнөх дэд бүлгээс үзнэ үү.

⁴⁵ Порнографийн материалыг жижиглэн худалдаалах, мөн ийм үйл ажиллагааг зохион байгуулах//

(2) Хэн нэгэн 18 насанд хүрээгүй этгээдийг төлбөртэйгөөр гуравдагч этгээдтэй буюу түүний дэргэд бэлгийн үйлдэл хийхэд бусдыг уруу татсан буюу гуравдагч этгээдийг өөртэй нь тийм үйлдэл хийх боломж олгосон буюу хэн нэгэн бусдыг зуучлан тийм үйлдэлд хамтран оролцсон бол 5 жил хүртэл хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(3) Хэн нэгэн ажлын буюу албаны харилцааны хүрээнд захиргаанд нь байгаа буюу түүнд хүмүүжүүлэх, боловсрол олгохоор итгэмжлэн хариуцуулсан, асран хамгаалуулсан арван найман нас хүрээгүй этгээдийг хүмүүжүүлэх, боловсрол олгох, харгалзан дэмжих, албаны болон ажлын харилцааны хараат байдлыг далимдуулан түүнийг гуравдагч этгээдтэй бэлгийн харьцаанд оруулахаар уруу татсан, түүний дэргэд буюу түүнийг гуравдагч этгээдтэй бэлгийн харьцаанд орох боломж олгосон бол 5 жил хүртэл хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ.

(4) 2 ба 3 дахь заалтад заасан үйлдэлд завдсан бол шийтгэлтэй.

§180а. Бие үнэлэхэд хамтран оролцох

(1) Хэн нэгэн аж ахуйн нэгж хэлбэрээр байгууллага бий болгох буюу түүний үйл ажиллагааг удирдаж, түүнд дараах байдлаар биеэ үнэлэх ажиллагаа явуулсан бол:

1. эрхшээлдээ байгаа этгээдийн хувийн болон эд хөрөнгийн хараат байдлыг ашигласан буюу;

2. өрөө байр буюу оршин суух болон түр байрлах бусад байр гаргаж өгөх, үүнтэй холбоотой нэмэгдэл үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авах байдлаар биеэ үнэлэх ажиллагаанд хамтран оролцсон бол гурван жил хүртэл хорих буюу мөнгөн торгуулиар шийтгэнэ.

(2) Мөн хэн нэгэн:

1. Арван найман насанд хүрээгүй этгээдэд бие үнэлэх зориулалтаар байр, амьдрах орон сууцыг үйлчилгээний хэлбэрээр гаргах өгөх буюу оршин суух газар, үйлчилгээний хэлбэрээр гаргаж өгсөн, буюу

2. Биеийг нь үнэлүүлэхийн тулд байр гаргаж өгсөн этгээд бусдыг бие үнэлэхийг албадах буюу үүнтэй холбоотойгоор (бэлгээр) мөлжсөн бол мөн адил шийтгэнэ.

ФРАНЦ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

Франц Улсын 1992 оны Эрүүгийн хуулийн “Бэлгийн хүчирхийлэл” гэсэн III хэсэгт хүчиндэх, бэлгийн бусад хүчирхийлэл, бэлгийн дарамт зэрэг үйлдлийг бие даасан зүйл болгон хуульчилжээ.

Хэсэг III. Бэлгийн хүчирхийлэл

§1. Хүчиндэх

Зүйл 222-23. -Хүч хэрэглэх, албадах, айлган сүрдүүлэх буюу хууран мэхлэх замаар бусдыг ямар нэгэн хэлбэрээр бэлгийн нэвтрэлтийг хүчиндэх

гэнэ. Хүчиндэх гэмт хэрэгт арван таван жил хорих ял шийтгэнэ.

Зүйл 222-24⁴⁶. -Хүчиндэх гэмт хэрэгт 20 жил ял шийтгэнэ:

1. Хэрэв гэмтэл учруулсан буюу архаг өвчин тусгасан;

2. Хэрэв 16 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн;

3. Хэрэв нас, өвчин, гэмтэл, бие махбодын болон сэтгэцийн эмгэгээс үүдсэн онцгой эмзэг байдал, эсхүл жирэмсэн нь илт мэдэгдэхээр байсан буюу мэдэж байсан этгээд зориуд санаатайгаар үйлдсэн;

4. Хэрэв энэ нь хууль ёсны, жам ёсны буюу босоо шугамын (цусан ба ясан) төрөл садангаас өргөж авсан буюу хохирогч хараат байгаа бусад этгээд үйлдсэн;

5. Хэрэв олгосон бүрэн эрхтэй холбоотойгоор эрх мэдлээ урвуулан ашиглаж үйлдсэн;

6. Хэрэв гүйцэтгэгч буюу хамтран оролцогчийн (зохион байгуулагч, хамжигч, зуучлагч) хувьд хэд хэдэн этгээд хамтран (бүлэглэн) үйлдсэн;

7. Хэрэв зэвсэг хэрэглэж буюу зэвсэг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн;

8. Хэрэв хохирогч олон нийтийн (мэдээллийн хэрэгсэл) холбооны теле-шугамаар гүйцэтгэгчтэй холбоо тогтоосон байдлаа урвуулан тухайн мэдээллийг нийтэд тараасан бол.

Зүйл 222-25. Хэрэв хохирогч нас барахад хүргэсэн бол 30 жил хорих ял шийтгэнэ.

Зүйл 222-26. Хэрэв хүчиндэхийн өмнө, хүчиндэх үед болон хүчиндсэний дараа зодох буюу харгис хэрцгий хандсан бол бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

§ 2. Бэлгийн бусад хүчирхийлэл

Зүйл 222-27. - Хүчиндэхээс бусад бэлгийн хүчирхийлэл үйлдвэл гянданд 5 жил хорьж, 500000 франкаар торгоно.

Зүйл 222-28⁴⁷ - 222-27 зүйлд заасан гэмт үйлдэлд гянданд 7 жил хорьж, 700000 франкаар торгоно:

1. Хэрэв (хохирогчид) шарх буюу бие махбодын гэмтэл учруулсан;

2. Хэрэв энэ нь хууль ёсны, жам ёсны буюу босоо шугамын төрөл садангаас өргөж авсан буюу хохирогч хараат байгаа бусад этгээд үйлдсэн;

3. Хэрэв олгосон бүрэн эрхтэй холбоотойгоор эрх мэдлээ урвуулан ашиглаж үйлдсэн;

4. Хэрэв гүйцэтгэгч буюу хамтран оролцогчийн (зохион байгуулагч, хамжигч, зуучлагч) хувьд хэд хэдэн этгээд хамтран (бүлэглэн) үйлдсэн;

5. Хэрэв зэвсэг хэрэглэж буюу зэвсэг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн;

⁴⁶ (в редакции закона № 98-468 от 17 июня 1998г.).

⁴⁷ (в редакции закона № 98-468 от 17 июня 1998 г.).

б. Хэрэв хохирогч олон нийтийн холбооны теле-шугамаар гүйцэтгэгчтэй энэ үйлдлийн холбоо тогтоосон байдлыг урвуулан тухайн мэдээллийг нийтэд (зориуд) түгээсэн бол.

Зүйл 222-29. - Хүчиндэхээс бусад бэлгийн хүчирхийлэлд гянданд 7 жил хорьж, 700000 франкаар торгоно, хэрэв:

1. 15 нас хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн;

2. Хэрэв (өндөр) нас, өвчин, гэмтэл, бие махбодын болон сэтгэцийн эмгэгээс үүдсэн онцгой эмзэг байдал, эсхүл жирэмсэн нь илт мэдэгдэхээр байсан буюу мэдэж байсан этгээдийн эсрэг үйлдсэн;

Зүйл 222-30. - 222-29 зүйлд заасан гэмт үйлдэлд 10 жил гянданд хорьж, 1000000 франкаар торгоно:

1. Хэрэв хүнд шархдуулсан буюу бие махбодод гэмтэл учруулсан;

2. Хэрэв энэ нь хууль ёсны, жам ёсны буюу босоо шугамын (ойрын цусан ба ясан) төрөл садангаас өргөж авсан буюу хохирогч хараат байгаа бусад этгээд үйлдсэн;

3. Хэрэв олгосон бүрэн эрхтэй холбоотойгоор эрх мэдлээ урвуулан ашиглаж үйлдсэн;

4. Хэрэв гүйцэтгэгч буюу хамтран оролцогчийн (зохион байгуулагч, хамжигч, зуучлагч) хувьд хэд хэдэн этгээд хамтран (бүлэглэн) үйлдсэн;

5. Хэрэв зэвсэг хэрэглэж буюу зэвсэг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол;

Зүйл 222-31. - Хуулийн 222-27-оос 222-30 зүйлд заасан зөрчил үйлдэхээр халдсан (завдсан) бол мөн адил ял шийтгэл хүлээнэ.

Зүйл 222-32. - Олон нийтийн анхаарал төвлөрсөн, бусдын анхаарал татах газар бэлэг эрхтнээ нийтэд харуулсан бол гянданд нэг жил хорих ял шийтгэж, 100000 франкаар торгоно.

§3. Бэлгийн дарамт⁴⁸

Зүйл. 222-33. – (Хуулиар) олгосон бүрэн эрхтэй холбоотойгоор эрх мэдлээ урвуулан ашиглаж бэлгийн шинжтэй давуу байдал олж авах зорилгоор амлалт өгөх, заналхийлэх, албадах, дарамт шахалт үзүүлэх замаар бусад этгээдэд дарамт үзүүлсэн бол гянданд 1 жил хорьж, 100 000 франкаар торгоно.

БНСУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

БНСУ-ын 1975, 1988, 1995, 1997, 2012 онд нэмэлт, өөрчлөлт орсон 1953 оны Эрүүгийн хуулийн “Хүчиндэх болон садар самуун үйлдэл” гэсэн 32 дугаар бүлэгт “Насанд хүрээгүй хүүхэдтэй хурьцал үйлдэх буюу садар самуун үйлдэл хийх” (§305), “Бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох” (§302) бие даасан бүрэлдэхүүнийг гэмт хэрэгт тооцжээ.

⁴⁸ (в редакции закона № 98-468 от 17 июня 1998 г.).

Бүлэг XXXII. Хүчиндэх болон садар самуун үйлдэл

Зүйл 297. Хүчиндэх

Аливаа этгээд хүч хэрэглэх буюу айлган сүрдүүлэх замаар эмэгтэй хүнтэй бэлгийн ажил хийсэн (харьцаанд орсон) бол гурван жилээс багагүй хугацаагаар хүнд ажил хийлгэх ялаар шийтгэнэ.

Зүйл 298. Садар самуун үйлдэл

Аливаа этгээд хүч хэрэглэх буюу айлган сүрдүүлэх замаар бусад этгээдийн эсрэг садар самуун үйлдэл хийсэн бол 10 жил хүртэл хүнд ажил хийлгэх буюу 50 сая хүртэл воноор торгох ялаар шийтгэнэ⁴⁹.

Зүйл 299. Хүчиндэх, садар самуун маягийн (ойролцоо, квази) үйлдэл

Аливаа этгээд хохирогчийн хөнгөмсөг зан үйл буюу түүний тусламж авах боломжгүй байдлыг ашиглах замаар эмэгтэй хүнтэй хурьцах буюу бусад хүнтэй садар самуун үйлдэл хийсэн бол өмнөх хоёр зүйлд заасан шийтгэл хүлээнэ.

Зүйл 300. Завдах

Өмнөх гурван зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхээр завдсан бол шийтгэл хүлээнэ.

Зүйл 301. Хүчиндсэний улмаас (хохирогч) нас барсан буюу бие махбодын гэм хор (хохирол) учрах

Хуулийн 297-300 зүйлд заасан үйлдэл хийсний улмаас бусад этгээд нас барсан буюу түүнд бие махбодод гэмтэл учирсан бол хүнд ажил 5 жилээс багагүй хугацаагаар буюу бүх насаар нь хийлгэх ял шийтгэнэ⁵⁰.

Зүйл 301-2. Хүчиндэж алах; үхэлд хүргэж хүчиндэх

Хуулийн 297-300 зүйлд заасан үйлдэл хийсэн этгээд хохирогчийг алсан бол цаазаар авах буюу бүх насаар нь хорих ял шийтгэнэ. Хэрэв энэ үйлдэл нь болгоомжгүйгээр үхэлд хүргэсэн бол гэм буруутай этгээдийг арав буюу түүнээс дээш жилийн хугацаагаар хорих буюу бүх насаар нь хорих ял шийтгэнэ⁵¹.

Зүйл 302. Бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох

Аливаа этгээд хууран мэхлэх буюу айлган сүрдүүлэх замаар насанд хүрээгүй хүүхэд буюу сэтгэцийн эмгэгтэй хүнтэй хурьцал үйлдсэн буюу садар самуун үйлдэл хийсэн бол 5 жил хүртэл хүнд ажил хийлгэх ял шийтгэнэ.

Зүйл 303. Мэргэжлийн байдлаа урвуулан ашиглаж хурьцал үйлдэх

(1) Бизнестэй холбоотойгоор түүний хамгаалалт буюу хараанд байгаа, түүнд ажиллаж байгаа болон бусад харилцаатай эмэгтэйг айлгах буюу хүч хэрэглэхээр сүрдүүлж хурьцал үйлдсэн этгээдийг 5 хүртэл жил хүнд ажил хийлгэх буюу 15 сая воноор торгох ял шийтгэнэ⁵².

⁴⁹ (Данная статья полностью дополнена Законом № 5057 от 29 декабря 1995 г.).

⁵⁰ (Данная статья полностью дополнена Законом № 5057 от 29 декабря 1995 г.).

⁵¹ (Данная статья полностью дополнена Законом № 5057 от 2 9 декабря 1995 г.).

⁵² (Дополнена Законом № 5057 от 29 декабря 1995 г.).

(2) Хуулийн дагуу түүний хамгаалалтад байгаа эмэгтэй хүнтэй хурьцал үйлдсэн бол 7 жил хүртэл хүнд ажил хийх ялаар шийтгэнэ.

Зүйл 304. Гэрлэх нэрийдлээр хурьцал үйлдэх

Ёс суртахуунтай эмэгтэйг⁵³ гэрлэх санал тавих буюу бусад хууран мэхлэх аргаар хурьцал үйлдэхэд (бэлгийн харьцаанд ороход) хүргэсэн бол 2 жил хүртэл хүнд ажил хийлгэх буюу 5 сая хүртэл воноор торгох ял шийтгэнэ⁵⁴.

Зүйл 305. Насанд хүрээгүй хүүхэдтэй хурьцал үйлдэх буюу садар самуун үйлдэл хийх.

Аливаа этгээд 13-аас бага насны эмэгтэйтэй хурьцал үйлсэн буюу тийм этгээдтэй садар самуун үйлдэл хийсэн бол хуулийн 297, 298, 301 буюу 301-2 зүйлд заасан ял шийтгэнэ⁵⁵.

Зүйл 306. Гомдол

Хуулийн 297, 298, 301 буюу 301-2 зүйлд заасан гэмт хэргийг зөвхөн гомдлын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж шалгана⁵⁶.

Зүйл 242 Биеэ үнэлэхэд татан оролцуулах

Аливаа этгээд орлого олох зорилгоор насанд хүрээгүй охиныг буюу ёс суртахуунтай эмэгтэйг сексийн үйлдэлд татан оролцуулсан бол 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих буюу 15 сая воноос илүүгүй воноор торгох ял шийтгэнэ.⁵⁷

ЯПОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

Япон Улсын Эзэн хааны 1907 оны (№45) хуулиар анх баталж, 1995 онд №91 хуулиар шинэчлэгдэж, 1999, 2017 онд нэмэлт, өөрчлөлт орсон Япон Улсын Эрүүгийн хуулийн 177-182 дугаар зүйлд, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, ялангуяа хүүхдийн эсрэг үйлдсэн энэ төрлийн гэмт хэргийг хуульчилсан байна. Япон Улсын Эрүүгийн хуульд хүчингийн гэмт хэргийг анх 1907 оноос гэмт хэрэгт тооцож ялтай болгожээ. Эрүүгийн хуулийн 2017 оноос бэлгийн хүчирхийллийг гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгасан байна.

Зүйл 177. Хүчиндэх

Аливаа этгээд 13 нас хүрсэн эм хүйстэй этгээдийг хүч хэрэглэх буюу айлгаж хүчирхийлсэн бол хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж, хоёроос дээш жилийн хугацаанд албадан хөдөлмөр эрхлүүлэн хорих ял шийтгэнэ. Мөн 13 нас хүрээгүй эм хүйстнийг (охидыг) хүчирхийлсэн этгээдэд ял шийтгэнэ.

Зүйл 178. Хүчиндэх, хүч хэрэглэн садарлахтай (ёс бусаар дур хүслээ хангах) адилтгах гэмт үйлдэл

⁵³ Солонгос, Япон зэрэг улс орны эрүүгийн хуульд ёс суртахуун, зан заншил уламжлалын дагуу “ёс зүйтэй, ёс суртахуунтай эмэгтэй” гэсэн нэр томъёог хэрэглэдэг байна.

⁵⁴ (Дополнена Законом № 5057 от 29 декабря 1995 г.)

⁵⁵ (Дополнена Законом № 5057 от 29 декабря 1995 г.).

⁵⁶ (Дополнена Законом № 5057 от 29 декабря 1995 г.).

⁵⁷ (Дополнена Законом № 5057 от 29 декабря 1995 г.).

Хэн нэгэн бусад этгээдийн ухаангүй буюу эсэргүүцэх чадваргүй байдлыг ашиглаж, эсхүл түүнийг ухаангүй буюу эсэргүүцэх чадваргүй байдалд хүргэж садар самуун үйлдэл хийсэн буюу хүчирхийлсэн бол өмнөх хоёр зүйлд заасан шийтгэл хүлээнэ.

Зүйл 179. Завдалт

Өмнөх гурван зүйлд заасан үйлдэл хийхээр завдсан бол ял шийтгэнэ.

Зүйл 180. Хувиараа яллах ба хувийн нэхэмжлэлээр яллах журмыг хэрэглэх

Өмнөх дөрвөн зүйлд заасан гэмт хэргийг зөвхөн хохирогчийн гомдлоор авч хэлэлцэнэ.

Хэрэв өмнөх дөрвөн зүйлд заасан гэмт хэргийг хоёр ба түүнээс дээш этгээд үйлдсэн бол энэхүү журмыг хэрэглэхгүй.

Зүйл 181. Хүч хэрэглэсэн садар самуун үйлдэл буюу хүчиндэхийн улмаас нас барах, бие махбодын гэмтэл учрах

Хэн нэгэн хуулийн 176-179 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэний улмаас бусад этгээд нас барсан буюу түүнд бие махбодын гэмтэл учирсан бол хугацаагүйгээр албадан хөдөлмөр эрхлүүлж хорих буюу гурваас доошгүй жил хорих ял шийтгэнэ.

Зүйл 182. Садар самуунд уруу татах

Аливаа этгээд шунахайн зорилгоор садар самуун бус эмэгтэйг уруу татсан бол 3 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлж хорих буюу 300 мянган иен хүртэл торгох ял шийтгэнэ.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШБС	Ахисан шатны боловсролын сургууль
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БНД	Багануур дүүрэг
БНКУ	Бүгд Найрамдах Казакстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХД	Багахангай дүүрэг
ГС	Глобал сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МБ	Мөрдөн байцаалт
МОНЭС	Монголын Эмэгтэйчүүдийн сан
НД	Налайх дүүрэг
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ХБ	Хэрэг бүртгэлт
ХБолгосон	Хэрэгсэхгүй болгосон
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХДХВ	Хүний дархлал хомсдлын вирус
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХУД	Хан-Уул дүүрэг
ЦБ	Цагдаагийн байгууллага
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦСТ	Цагдаа судлалын төв
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШСЭСК	Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиник
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШҮХ	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХҮ	Эрүүгийн хэрэг үүсгэх
ЭШХ	Эрдэм шинжилгээний хүрээлэн

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Нэг. Цагдаагийн байгууллагын мэдээлэлтэй холбоотой

- График 1. “Хүчиндэх”, “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах”, “арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэмт хэрэг бүртгэгдсэн байдал
- График 2. Хүчиндэх гэмт хэрэгт хохирсон хүүхдийн насны ангилал
- График 3. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт хохирсон хүүхдийн насны ангилал
- График 4. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт хохирсон хүүхдийн насны ангилал
- График 5. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, хохирогч
- График 6. Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн шийдвэрлэлт

Хоёр. Прокурорын байгууллагын мэдээлэлтэй холбоотой

- График 7. Гэмт хэргийн байдал
- График 8. Хүчиндэх гэмт хэргийн шийдвэрлэлт
- График 9. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шийдвэрлэлт
- График 10. 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн шийдвэрлэлт

Гурав. Шүүхийн мэдээлэлтэй холбоотой

- График 11. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

Дөрөв. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээлэлтэй холбоотой

- График 12. 2018 оны байдлаар хүчиндэх гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй нийт хоригдлын тоо, хохирогчдын насны ангилал
- График 13. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын нас
- График 14. Хоригдлын хөдөлмөр эрхлэлт
- График 15. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн төлбөртэй хоригдлын тоо
- График 16. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын төлбөр барагдуулалт

Тав. Шүүхийн шинжилгээний байгууллагын мэдээлэлтэй холбоотой

- График 17. Шүүхийн шинжилгээний байгууллагад хүчиндэх гэмт хэрэгтэй холбоотой хийсэн шинжилгээ
- График 18. Дээрх шинжилгээнд хамрагдсан хүүхдийн насны байдал
- График 19. Шүүх эмнэлгийн үзлэг, биологийн шинжилгээгээр эр бэлгийн эс илэрсэн байдал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Эр бэлгийн эс илрүүлэх шинжилгээний үзүүлэлт
- Хүснэгт 2. Ялын харьцуулалт

